



МОНГОЛЫН ҮНДЭСНИЙ
ХУДАЛДАА АЖ ҮЙЛДВЭРИЙН
ТАНХИМ

2022

ANNUAL REPORT

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ

ТАЙЛАН



АГУУЛГА

МЭНДЧИЛГЭЭ

ГИШҮҮНЧЛЭЛ

БОДЛОГЫН ӨМГӨӨЛӨЛ

СУДАЛГАА

ХАМТЫН АЖИЛЛАГАА

АРГА ХЭМЖЭЭ

ШАГНАЛ, ШАЛГАРУУЛАЛТ

ҮЗЭСГЭЛЭН ЯАРМАГ

ТӨСӨЛ ХӨТӨЛБӨР

ТАНХИМЫН ҮЙЛЧИЛГЭЭ

СУРГАЛТ

МОНГОЛЫН ОЛОН УЛСЫН АРБИТР

ТАНХИМЫН ДОТООДОД ХЭРЭГЖҮҮЛСЭН АЖИЛ

САЛБАР ТАНХИМ

ХАВСРАЛТ





● ЭРХЭМ ЗОРИЛГО

МҮХАҮТ нь бизнесийн таатай орчныг бүрдүүлэхэд нөлөөлөгч, өмгөөлөгч, бизнесийн хөгжилд чиглүүлэгч, холбогч, дэмжигч байна.



● АЛСЫН ХАРАА

МҮХАҮТ нь бизнесийн амжилтын ТАЛБАР байж, дэлхийн зах зээлийн өрсөлдөөнд манлайлахад ХӨТӨЧ нь болно.



● ҮНЭТ ЗҮЙЛС

Чадварлаг, эвсэг хамт олон
Нягт, үр дүнтэй хамтын ажиллагаа
Үнэ цэнтэй бүтээгдэхүүн, үйлчилгээ
Ёс зүйт үйл ажиллагаа
Манлайлал



СТРАТЕГИЙН ЗОРИЛТУУД

ЕРӨНХИЙЛӨГЧ

ИЛ ТОД МАНЛАЙЛАЛ

Ил тод стратегийг ил тод манлайллаар хэрэгжүүлнэ

THINK TANK CLUB

БИЗНЕСИЙН ОРЧНЫ
БОЛОН САЛБАРЫН
БОДЛОГЫН ШИЙДЭЛ
ГАРГАДАГ БОЛОХ

Бизнесийн орчны болон бодлогын шийдлийг тодорхойлох чадамжтай байх
Бодлогод нөлөөлдөг байх

SME САНХҮҮЖИЛТ

САНХҮҮЖИЛТИЙН
ШИЙДЭЛТЭЙ
БАЙГУУЛЛАГА БОЛОХ

Санхүүжилтийн шийдэл Гадаад худалдаа, экспортыг дэмжих

ОРОЛЦООНД СУУРИЛСАН ШИЙДЭЛ / ГИШҮҮД /

ОЛОН НИЙТЭД НӨЛӨӨ
БҮХИЙ БАЙГУУЛЛАГА
БАЙЖ БИЗНЕС
ЭРХЛЭГЧДИЙН НЭР
ХҮНДИЙГ ӨНДӨРТ ӨРГӨХ

Бүтцийн өөрчлөлт (Газарзүйд суурилсан → Үнэ цэнд суурилсан)
Гишүүн нэмэгдүүлэх (5.000 → 50.000)



МЭНДЧИЛГЭЭ

МҮХАҮТ 2022 онд Монгол Улсын эдийн засгийн тулгамдсан асуудлууд, цар тахлын дараах бизнесийн орчинд дүн шинжилгээ хийж, шийдвэрлэх гарц шийдлүүдийг дэвшүүлэн тавьж, тодорхой ажлуудыг авч хэрэгжүүллээ.

МҮХАҮТ-аас гадаадын шууд хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх улсын төсвийн үр ашгийг нэмэгдүүлэх, алдагдлыг бууруулах, төсвийн төлөвлөлтийг сайжруулах, төрийн ба олон нийтийн өмчөөр худалдан авалт хийх, төрийн хяналт шалгалтыг бууруулах зэрэг асуудлаар УИХ, Засгийн газар болон холбогдох яамдуудтай хамтран уулзалт хэлэлцүүлгүүдийг зохион байгуулж, шаардлагатай судалгааг хийж, тодорхой санал зөвлөмжүүдийг хүргэж ажилласан.

Худалдаа Аж Үйлдвэрийн Танхимын тухай хуулийн төслийн үзэл баримтлал, ач холбогдлын талаар төр, олон нийтэд таниулах ажлуудыг хийсэн бөгөөд бусад орны Худалдаа аж үйлдвэрийн танхимын тогтолцоо, хууль эрх зүй, шинэчлэлийн талаар нарийвчлан судалсны үндсэн дээр уг хуулийн төслийг шинэчлэн 2022 оны 12 дугаар сард Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж дэмжлэг авсан нь энэхүү хуулийн төслийг УИХ-аар цааш хэлэлцүүлэхэд нэг чухал алхам болсон.

МҮХАҮТ-ын 1000 CEO, 1000 ХҮЧИРХЭГ КОМПАНИ хөтөлбөрийн хүрээнд 2022 оны 9 дүгээр сард танхимын дэргэдэх Бизнес Академиас санаачлан зохион байгуулсан "CEO RADAR" арга хэмжээнд 300 гаруй гүйцэтгэх болон дундаас дээш түвшний удирдлага арга туршлагаасаа хуваалцаж, цар тахлын дараах шинэ хэвийн байдалд бизнесээ сэргээхэд тулгамдаж буй асуудлууд, гарц шийдлээ хамтдаа тодорхойлсон бөгөөд эдгээр оролцогчид нэгдэн "CEO RADAR" сүлжээний эхлэлийг тавьсан нь чухал үйл явдал болов.

2022 оны 10 дугаар сард Монгол Улсын Ерөнхий сайдын ивээл дор "Экспортлогч үндэстэн-Шинэ сэргэлтийн бодлого чуулган"-ыг Монголбанктай хамтран зохион байгуулсан бөгөөд уул уурхайн бус экспортыг нэмэгдүүлэхэд нэн тэргүүнд авч хэрэгжүүлэх арга хэмжээнүүдийг Монгол Улсын Засгийн газрын хуралдаанд танилцуулсны дүнд Ерөнхий сайдын захирамжаар "Уул уурхайн бус бүтээгдэхүүний нэр төрлийг судлан тодорхойлж, экспортыг нэмэгдүүлэхэд чиглэсэн арга хэмжээний цогц санал боловсруулан танилцуулах үүрэг бүхий зөвлөл" байгуулагдан ажиллаж эхэлсэн.

Монгол Улс цар тахлын ул мөр, ОХУ ба Украин хоорондын дайнаас үүссэн геополитикийн нөхцөл байдал болон төсвийн үр ашиггүй байдал, төрийн хэт оролцоо, хавтгайрсан халамж, авилгалын томоохон хэргүүд гээд эдийн засаг, нийгмийн олон ужиг асуудлыг шийдвэрлэхийн тулд эрс шинэчлэл хийх зайлшгүй шаардлагатай тулгарсан түүхэн цаг үе дээр байна. Энэхүү шинэчлэлийг хийхэд хувийн хэвшлийн нэгдмэл байдал, нэгдсэн байр суурь чухал бөгөөд үүнийг МҮХАҮТ-ын гишүүн байгууллагууд манлайлна гэдэгт итгэл дүүрэн байна. Та бүхэнд сайн сайхныг хүсье.



МЭНДЧИЛГЭЭ

МҮХАҮТ-ын хувьд 2022 он Монгол Улсын эдийн засаг, бизнесийн орчныг сайжруулах, хөрөнгө оруулалт татах, бизнес эрхлэгчдийн нийтлэг эрх ашгийг хамгаалах, дуу хоолойг төлөөлөх, дэмжин урамшуулах, хамтын ажиллагааг эхлүүлэх чиглэлээр олон талт үйл ажиллагааг эрчимжүүлсэн жил байлаа. Хүндрэл, бэрхшээл, сорилт бүхнийг даван туулахын төлөө хувийн хэвшил шаргуу хөдөлмөрлөж, зүтгэсэн жил ард үлдэж, 2023 он өсөлт, хөгжлийн өнгө төрхийг тодорхойлно гэдэгт эргэлзэхгүй байна.

Бизнесийн үйл ажиллагаа эргэн сэргэсэн, гадаад, дотоод хамтын ажиллагаа идэвхжсэн, худалдааны эргэлт сайжирсан, эдийн засаг оны төгсгөлд өсөлттэй гарсан нь аж ахуйн нэгжүүдийн үүрэг, оролцоог тодотгоно. МҮХАҮТ эдгээр эерэг өөрчлөлтийн төлөө үйл ажиллагаагаа чиглүүлж, экспортыг төрөлжүүлэх, бизнесийн үйл ажиллагааг ёс зүйтэй хослуулах, компанийн сайн засаглалыг бэхжүүлэх, харилцаа холбоо, хамтын ажиллагааг өргөжүүлэх, олон улсад Монголын бизнесүүд танигдах, бусадтай хамтрах, шинэ түншлэл эхлүүлэхэд гүүр болон ажиллав. Г и ш ү ү н байгууллагуудынхаа гадаад харилцаа, хамтын ажиллагааг өргөжүүлэх, эрчимжүүлэх, хөрөнгө оруулалт татах, экспортын тоо хэмжээг нэмэгдүүлэх зорилгоор гадаад, дотоодод томоохон форум, B2B уулзалтууд, туршлага судлах зэрэг арга хэмжээнүүдийг амжилттай зохион байгууллаа. Нийт 65 цахим болон танхим хосолсон уулзалтыг зохион байгуулсан.

Монгол Улсын нийт экспортын 94 хувийг өдгөө эрдэс баялгийн бүтээгдэхүүн бүрдүүлж, сүүлийн 20 гаруй жилийн хугацаанд уул уурхайн бус бүтээгдэхүүний экспортод эзлэх хувь хэмжээ буурч байгаа нь анхаарах асуудлын нэг. Тиймээс үүнийг өөрчлөх, засаж залруулахад манлайлал үзүүлэн, судалгаанд суурилсан санаачилга дэвшүүлж, бодит ажлын эхлэлийг тавьсан. Орхигдсон боломжийг таниулах, эдийн засгийн ээлжит боломж нь уул уурхайн бус экспорт гэдгийг батлан харуулахыг зорив.

МҮХАҮТ уул уурхайн бус экспортыг дэмжих санхүүжилтийн тогтолцоог хөгжүүлэх, төр, хувийн хэвшил, хөрөнгө оруулагчдын оролцоог хангах, хамтран ажиллах боломж, гарцыг идэвхийлэн эрэлхийлсэн жил 2022 он байв. Экспортын санхүүжилтийн арга хэрэгслүүдийг нэвтрүүлэх, тогтолцоог бий болгох, хүртээмжийг сайжруулахаар Монголбанк, Монгол Улсын Хөгжлийн банкттай хамтын ажиллагааг эхлүүлсэн.

Гишүүн байгууллагуудынхаа эгнээг нэмэгдүүлж, цар хүрээг өргөжүүлэх, тэдэндээ хүрч ажиллах, шинэ үйлчилгээ нэвтрүүлэх, бизнесийн үйл ажиллагааг дэмжих, борлуулалтыг нэмэгдүүлэх чиглэлд анхаарч ажиллаа. 2022 онд Дэлхийн экспо "Дубай-2020"-г амжилттай зохион

байгуулсанаар Монгол Улсын асраар 365 мянга гаруй хүн зочлон, 111 мянга гаруй ам.долларын борлуулалт хийгдсэн.

Монгол Улс дахь бизнесийн ёс зүй, шударга байдлыг бэхжүүлэх, бизнесийн таатай орчныг бүрдүүлэх чиглэлд идэвх санаачилга гарган ажилладаг байгууллагын хувьд “Транспэрэнси Интернэшнл Монгол” ТББ, “Рио Тинто Монгол” ХХК-тай хамтран МҮХАҮТ-ын дэргэд “Бизнесийн ёс зүйн төв”-ийг байгуулан, үйл ажиллагаагаа амжилттай хэрэгжүүлж байна.

Худалдааг ил тод болгох чиглэлд тодорхой алхмууд гарлаа. Монгол-Хятадын харилцан ашигтай байх худалдааны орчныг бүрдүүлэх хамтын ажиллагаа тодорхой үр дүнд хүрч, хоёр орны худалдаанд тулгамдсан хүндрэл бэрхшээл, маргаантай асуудлуудыг харилцан зөвшилцөх замаар үе шаттай шийдвэрлэхэд санамж бичгийг Хятадын Олон Улсын Худалдааг Дэмжих Хороо (ССРIT) -той байгуулав.

Гадаад, дотоод харилцаа холбоо эргэн сэргэсэн, уламжлалт үйл ажиллагаа тэлж, цар хүрээ нь өргөжсөн жил 2022 он байлаа. Бизнес эрхлэгчдэдээ амжилт хүсье.






ГИШҮҮНЧЛЭЛ

МҮХАҮТ нь үндэсний хэмжээнд аж ахуйн нэгжүүдийг эгнээндээ нэгтгэн гишүүнчлэлийнхээ цар хүрээг өргөжүүлсээр байгаа төдийгүй бизнес эрхлэгчид, ялангуяа бичил, жижиг дунд бизнес эрхлэгчид Танхимд хандан мэдээлэл, үйлчилгээ авах эрэлт хэрэгцээ нь нэмэгдсээр байна.

Гишүүдийн тоо 2022 онд 5736 болж өссөнөөс Улаанбаатар хотын гишүүн байгууллагын тоо 2382, орон нутгийн гишүүн байгууллагын тоо 3354 болж өмнөх оноос 324-өөр буюу 6 хувиар нэмэгдсэн байна.


● ГИШҮҮДИЙН ТОО



● 2022 ОНД НЭМЭГДСЭН НИЙТ ГИШҮҮДИЙН ТОО



● УЛААНБААТАР ХОТЫН ГИШҮҮДИЙН АНГИЛЛЫН ТОО





SPONSOR



DIAMOND



PLATINUM



GOLD



STANDARD

MNCCI Honor Wall



The Premier voice of Business

Sponsors

MONSIEUR	TESCO	WALMART
...

Diamond

...
...

Platinum


...
...

Grand HAL




● ҮНДЭСНИЙ ХЭМЖЭЭНИЙ АЖ АХУЙН НЭГЖҮҮДИЙН МЭДЭЭЛЛИЙН НЭГДСЭН СИСТЕМ

МҮХАУТ-ын гишүүн байгууллагууд, бизнес эрхлэгчдэд зах зээлээ өргөжүүлэх, өрсөлдөх чадвараа нэмэгдүүлэх, үндэсний хэмжээний аж ахуйн нэгжүүдийн мэдээллийн нэгдсэн сүлжээнд нэгдэх, мэдээллээ эмх цэгцтэй нэг байршилд төвлөрүүлэн нийтэд хүргэхэд нь дэмжлэг үзүүлэх, байгууллагынхаа бүтээгдэхүүн үйлчилгээний маркетингийн сувгийг нэмэгдүүлэх, ААН байгууллага, хувь хүмүүстэй холбоо тогтоох, харилцан хамтран ажиллах бизнесийн төрөл бүрийн санал тавих зорилгын хүрээнд тодорхой ажлуудыг хийж гүйцэтгэсэн.



Өөрийн домэйн нэргүй жижиг, дунд, бичил аж ахуйн нэгжүүдэд хувийн орон зайгаа үүсгэх, бараа бүтээгдэхүүн, нийтлэл, арга хэмжээ, зөвлөмж, ярилцлага, мэдээлэл зэргийг нийтэд мэдээлэх, түгээх, сурталчлах зорилгоор дэд домэйн /example.trademongolia.mn/ үүсгэж ашиглах боломжийг бүрдүүлж өгсөн. Мөн Trademongolia.mn веб сайтын гар утсанд зориулсан веб аппликейшныг App Store болон Play Store дээр байршуулсан.



Аж ахуйн нэгж, байгууллагуудын бүтээгдэхүүн, үйлчилгээг гадаад улс орны бизнес эрхлэгч, хөрөнгө оруулагч нарт сурталчлан таниулах, холбоо тогтоож хамтран ажиллах зорилгоор Англи хэлээр хөгжүүлэхийн зэрэгцээ Монголоос бараа бүтээгдэхүүнээ экспортод гаргадаг байгууллагуудын бүтээгдэхүүний танилцуулга, мэдээ мэдээлэл зэргийг багтаасан Mongolian Exporters хэсгийг бий болгон хөгжүүлж байна.

Trademongolia.mn веб сайтад нийт 5902 байгууллага, аж ахуйн нэгж, хувиараа бизнес эрхлэгч нарын мэдээлэл, 2055 бүтээгдэхүүн үйлчилгээний мэдээлэл тус тус байршсан байна.

● МҮХАҮТ-ЫН СЭТГЭЛ ХАНАМЖИЙН СУДАЛГААНЫ ТОВЧ ҮР ДҮН

Судалгааг 2022 оны 11-12 дугаар саруудад Улаанбаатар хот болон орон нутагт үйл ажиллагаа явуулдаг, МҮХАҮТ-ын гишүүн болон гишүүн бус нийт 1684 бизнес эрхлэгчийг хамруулан явуулсан.


Бизнес эрхлэгчдийн 77 хувьд нь МҮХАҮТ-ын бизнес эрхлэгчдэд чиглэсэн үйлчилгээ, арга хэмжээ тухайн бизнесийн үйл ажиллагаанд дэмжлэг болдог гэжээ. МҮХАҮТ-аас үйлчилгээ авахад хүнд суртал байгаа эсэхийг тодруулахад бизнес эрхлэгчид Танхимын үйлчилгээнд 3.72 үнэлгээ өгсөн ба энэ нь төрийн үйлчилгээний үнэлгээнээс 0.71 пунктээр илүү сайн ба төрийн үйлчилгээтэй харьцуулахад МҮХАҮТ-аас үйлчилгээ авахад хүнд суртал бага гэж үнэлсэн. Бизнес эрхлэгчдийн зүгээс МҮХАҮТ-аас үйлчилгээ авахад харилцдаг ажилтны харилцаа хандлага мэргэжлийн ур чадвар, үйл ажиллагаа үйлчилгээтэй холбогдох мэдээллийн хүртээмжтэй байдалд хамгийн сайн үнэлгээ өгсөн бол үйлчилгээ авахад бүрдүүлдэг баримт бичгийн тоонд бага үнэлгээ өгсөн байна.

Мөн бизнес эрхлэгчдийн зүгээс цаашид МҮХАҮТ-ын үйл ажиллагааг


- Төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх, зуучлах (49%),
- Бизнесийг дэмжих зөвлөгөө өгөх, сургалт хийх (47%),
- Бизнес форум үзэсгэлэн зохион байгуулах (43%),
- Бизнесийн шаардлагатай судалгаа хийх (37%)

зэрэгт анхаарч ажиллах нь бизнест илүү эерэг үр нөлөөтэй байна гэжээ.

МҮХАҮТ-ын үйлчилгээний хүнд сурталын үнэлгээ



Дундаж үнэлгээ



Тайлбар:

1-маш их хүнд сурталтай,
5-хүнд сурталгүй

- МҮХАҮТ-ын үйлчилгээ
- Төрийн үйлчилгээ



БОДЛОГЫН ӨМГӨӨЛӨЛ

МҮХАҮТ нь бодлогын өмгөөлөл, нөлөөллийн чиг үүргийнхээ хүрээнд 2022 онд бизнестэй холбоотой хуулийн төсөл, эрх зүйн ба бодлогын баримт бичиг боловсруулах ажлын хэсгүүдэд орж ажиллан, бодлогын уулзалт хэлэлцүүлгүүдийг зохион байгуулж, бизнес эрхлэгчдийн саналуудыг нэгтгэн төр засагт хүргэн ажиллалаа.

МҮХАҮТ-аас 2022 оны 9 дүгээр сард эдийн засаг бизнесийн орчинд тулгарч байгаа асуудлуудыг үнэлэн, авах шаардлагатай арга хэмжээнүүдийг тодорхойлсон “Цар тахлын дараах бизнесийн орчны судалгаа”-ны тайланг УИХ, Засгийн газарт танилцуулсан.



МҮХАҮТ-аас санаачлан боловсруулсан Худалдаа Аж Үйлдвэрийн Танхимын тухай хуулийн шинэчилсэн найруулгыг УИХ-ын Эдийн засгийн байнгын хороогоор хэлэлцүүлсэн бөгөөд хууль санаачлагч гишүүд хуулийн төслийг буцаан татсан. Бусад орны Худалдаа аж үйлдвэрийн танхимын тогтолцоо, шинэчлэл, эрх зүйн байдлын талаар нарийвчилсан судалгааг хийсний үндсэн дээр уг хуулийн төслийг дахин шинэчлэн 2022 оны 12 дугаар сард Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж дэмжигдсэн.

2022 онд МҮХАҮТ-аас нийт 20 гаруй хуулийн болон бодлогын баримт бичиг боловсруулах ажлын хэсэгт орж ажилласан бөгөөд 30 шахам хуулийн болон бодлогын баримт бичгийн төсөлд санал хүргүүлсэн. Тухайлбал 2023 оны Улсын төсвийг хэлэлцэхтэй холбоотойгоор төсвийн төлөвлөлтийн асуудлаар УИХ-ын гишүүн Төсвийн байнгын хорооны дарга, ЭЗБХорооны дарга нар, томоохон аж ахуйн нэгжүүдийг оролцуулсан уулзалт хэлэлцүүлгийг зохион байгуулсан. Мөн УИХ-аас явуулсан хэлэлцүүлгүүдэд идэвхтэй оролцсон ба Улсын төсвийн төсөлд дүн шинжилгээ хийж, санал бэлтгэн хүргүүлсэн. Мэргэжлийн боловсролын сургалтыг сайжруулах хосмог тогтолцоог нэвтрүүлэх чиглэлээр холбогдох яамдууд, байгууллагуудтай туршлага судлах, хамтын ажиллагааны санамж бичиг байгуулах зэргээр хамтран ажилласан бөгөөд энэ чиглэлээр Боловсролын багц хуулийн ажлын хэсэгт ажиллаж байна.



● САНАЛ ӨГСӨН БУСАД ГОЛ ХУУЛИЙН ТӨСЛҮҮД:

- ▶ Төр хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийн төсөл
- ▶ Төрийн болон орон нутгийн өмчит компанийн тухай хуулийн төсөл
- ▶ Онцгой албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл
- ▶ Мөнгөн зээлийн үйл ажиллагааг зохицуулах тухай хуулийн төсөл
- ▶ Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах хуулийн төсөл

Төрийн ба орон нутгийн өмчөөр худалдан авалт хийх, төр ба хувийн хэвшлийн түншлэл болон төрийн бүтээмжийн эрх зүйн шинэтгэл сэдвүүдээр ЗГХЭГ-тай хамтран хэлэлцүүлгүүдийг зохион байгуулсан бөгөөд хэлэлцүүлэг дээр гарсан саналуудыг холбогдох байгууллагуудад хүргэж ажилласан.

2022 оны 10 дугаар сарын 28-нд Монгол Улсын Ерөнхий сайдын ивээл дор “Экспортлогч үндэстэн- Шинэ сэргэлтийн бодлого чуулган”-ыг Монголбанк ба МҮХАҮТ хамтран зохион байгуулсан бөгөөд энэхүү арга хэмжээнд Монгол Улсын Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэ, Шадар сайд С.Амарсайхан, Гадаад харилцааны сайд Б.Батцэцэг, Монголбанкны ерөнхийлөгч Б.Лхагвасүрэн, холбогдох албаны хүмүүс болон аж ахуйн нэгж, мэргэжлийн холбоодын төлөөлөл нийт 250 гаруй оролцогч оролцсон.



Чуулган дээр гарсан саналуудыг нэгтгэн, эрэмбэлээд экспортыг дэмжих, уул уурхайн бус экспортыг нэмэгдүүлэхэд нэн тэргүүнд авч хэрэгжүүлэх шаардлагатай арга хэмжээнүүдийг тодорхойлж МҮХАҮТ-ын ерөнхийлөгч О.Амартүвшин тэргүүтэй төлөөллүүд Монгол Улсын Засгийн газрын хуралдаанаар танилцуулсан. Энэ танилцуулгын мөрөөр 2022 оны 11 дүгээр сарын 17-ны өдөр экспортыг дэмжих чиглэлээр төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааг өргөжүүлэх талаар авах арга хэмжээний тухай Ерөнхий сайдын албан даалгавар гарсан ба албан даалгаврын дагуу Ерөнхий сайдын 2022 оны 12 дугаар сарын 8-ны өдрийн 212 тоот захирамжаар “Уул уурхайн бус бүтээгдэхүүний нэр төрлийг судлан тодорхойлж, экспортыг нэмэгдүүлэхэд чиглэсэн арга хэмжээний цогц санал боловсруулан танилцуулах үүрэг бүхий зөвлөл” байгуулагдан ажиллаж эхэлсэн.

МҮХАҮТ-аас МУХБ-аас олгосон зээлүүдийн талаар үнэн зөв мэдээлэл олон нийтэд хүргэх, хуш модны самрын экспорт, татварын өртэй ААН-үүдийн татварыг хөнгөлөх, төлөх хугацааг сунгах зэрэг цаг үеийн асуудлаар Танхимын байр суурийг илэрхийлсэн мэдэгдлүүдийг гаргасан.

МҮХАҮТ-аас 2022 онд бодлогын асуудлаар 50 гаруй уулзалт, хэлэлцүүлгийг дангаар болон холбогдох байгууллагуудтай хамтран зохион байгуулсан.



● БУСАД ТОМООХОН УУЛЗАЛТ ХЭЛЭЛЦҮҮЛГҮҮД:

- ▶ ЗГХЭГ-тай хамтарсан Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах хуулийн төсөл болон төр хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийн төслийн нээлттэй хэлэлцүүлэг
- ▶ Монгол Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар МҮХАҮТ-ын УЗ-ийн төлөөлөлтэй хийсэн уулзалт
- ▶ Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэ Top-100 аж ахуйн нэгжийн төлөөлөлтэй хийсэн уулзалт
- ▶ УИХ-ын Эдийн засгийн байнгын хороотой хамтарсан Зөвшөөрлийн тухай хуулийн төслийн танилцуулах уулзалт
- ▶ Хотын төвлөрлийг сааруулах чиглэлээр Ерөнхий сайд болон Боловсрол, шинжлэх ухааны сайдтай хийсэн уулзалт
- ▶ МҮХАҮТ-аас Гадаад харилцааны яам, Монголбанктай хамтран ОХУ-ын Засгийн газраас эдийн засгийн тусгай арга хэмжээ авах шийдвэр гарсантай холбогдуулан гадаад худалдаа эрхлэгч нарт зориулсан уулзалт
- ▶ Аялал жуулчлал болон зочлох үйлчилгээний салбарт мэргэжлийн хяналтын байгууллагын хяналт, шалгалтыг бууруулахтай холбоотой санал солилцох уулзалт

- ▶ Боловсрол, шинжлэх ухааны яамтай хамтарсан Мэргэжлийн боловсролын тухай хэлэлцүүлэг
- ▶ Бизнесийн холбогдолтой хууль тогтоомжийн талаар ХЗДХЯ, Сангийн яам, Гадаадын иргэн харьяатын газартай хамтран ажиллах талаар хэлэлцүүлэг
- ▶ Хөрөнгө оруулалтын эрх зүйн орчинд тулгамдаж буй асуудлууд, шинэчлэх хэрэгцээ сэдэвт ХЗДХЯ-тай хамтарсан хэлэлцүүлэг
- ▶ Хөшигийн хөндийн эдийн засгийн чөлөөт бүсийн захиргаатай хийсэн уулзалт
- ▶ Мэргэжлийн боловсрол, сургалт ба ажил олгогчдын хамтын ажиллагаа зөвлөлдөх уулзалт
- ▶ Төр хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийн хэлэлцүүлэг
- ▶ Гадаадын ажиллах хүч, цахим виз, хөрөнгө оруулалт, хил орчмын аялал жуулчлалыг хөгжүүлэх талаар санал солилцох нь сэдэвт уулзалт
- ▶ Чөлөөт бүсийн хөгжлийн бодлого хэлэлцүүлэг
- ▶ Мөнгөний бодлогын үндсэн чиглэл, эдийн засгийн төлөв уулзалт
- ▶ Төсвийн бодлогын шинэчлэл хэлэлцүүлэг
- ▶ Өвлийн аялал жуулчлал-Асуудал, Шийдэл хэлэлцүүлэг



МҮХАҮТ-ын дэргэдэх Аялал жуулчлалын зөвлөлөөс цар тахлын нөлөөлөл, аялал жуулчлалын салбарыг эргэн сэргээх чиглэлээр олон улсын 50 гаруй төлөвлөгөө болон судалгааны ажлуудыг судлан дүгнэлт хийж, мөн дотоодын 200 аж ахуйн нэгж, 30 экспертийн дунд явуулсан түүвэр судалгааны үр дүнг үндэслэн "Шинэ хэвийн байдал аялал жуулчлалыг сэргээх стратеги төлөвлөгөө"-г боловсруулан гүйцэтгэж БОАЖЯ-нд хүргүүлсэн.



МҮХАҮТ-ын дэргэдэх Хууль зүйн бодлогын зөвлөлийг 2022 оны 9 дүгээр сард шинэчлэн байгуулсан бөгөөд Зөвлөлийн бүрэлдэхүүнд аж ахуйн нэгжүүдийн хуулийн албаны захирлууд, ахлах хуульчид, МУИС-ийн Хууль зүйн сургуулийн профессор, Монголын Олон Улсын Арбитрын арбитрчид багтаж байна. МҮХАҮТ-ын ерөнхийлөгч болон уг зөвлөлийн төлөөллүүд ХЗДХЯ-ны Төрийн нарийн бичгийн даргатай уулзалт зохион байгуулж, бизнесийн эрх зүйн орчныг сайжруулах, хувийн эрх зүйн шинэтгэл хийх талаар хамтран ажиллах тухай ярилцсан. Энэ уулзалтаар яригдсаны дагуу МҮХАҮТ ба ХЗДХЯ-ны хооронд бизнес эрхлэх хууль, эрх зүйн таатай орчинг бий болгоход төр, хувийн хэвшлийн түншлэлийн тогтолцоог хөгжүүлэх зорилготой хамтын ажиллагааны санамж бичгийн зурсан.



МҮХАҮТ-ын дэргэдэх Ноос, ноолуурын зөвлөлөөс салбарын бодлогыг боловсруулах, хүний нөөц, өрсөлдөх чадвар, бүтээгдэхүүний хөгжүүлэлт хариуцсан ажлын хэсгүүд байгуулан ажилласан. Мөн НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн дэргэдэх Монголын Тогтвортой Ноолуурын Платформ хамтран ноолуурын үйлдвэрүүдтэй танилцах аяллыг зохион байгуулсан. Тус аялалд ноос, ноолуурын салбарын 18 компанийн 45 гаруй төлөөлөл болон ЕБС-ийн 11, 12 дугаар ангийн 45 сурагч хамрагдаж, Монгол нэхмэл ХК, Гоёл ХХК, Говь ХК, Ханбогд кашемир ХХК-уудтай танилцсан.

2022 онд МҮХАҮТ-ын төлөөлөл шинээр 29 хороо, зөвлөл комисст гишүүнээр орж ажилласан бөгөөд нийт 72 зөвлөл хороонд ажиллаж байна.



СУДАЛГАА

Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн Танхим нь бизнесийн орчны өнөөгийн байдал, түүнд нөлөөлөгч хүчин зүйлсийн үнэлгээ болон орчныг сайжруулахад шаардлагатай арга хэмжээг тодорхойлж уг арга хэмжээг хэрэгжүүлэхэд Төрийн болон ТББ-ын үүрэг оролцоог нэмэгдүүлэх зорилгоор “Бизнес итгэлийн индекс-2021”, “Хүнд суртлын индекс-2021” зэрэг нийт 16 судалгааг хийлээ.

● БИЗНЕС ИТГЭЛИЙН ИНДЕКС-2021



Бизнесийн итгэлийн индекс нь бизнесийн орчны өөрчлөлтийг хэмжих боломжийг олгодог онцлогтой судалгаа бөгөөд МҮХАҮТ-аас тус судалгааг 2001 оноос хойш жил бүр тасралтгүй явуулж байна. 2021 оны бизнес итгэлийн индекс судалгаа нь олон улсын харилцаа, гадаад худалдааны тодорхойгүй, тааламжгүй орчин нөхцөл үүссэн, дотооддоо цар тахлын дараа бизнес, эдийн засгаа сэргээх амаргүй цаг үед хийгдсэнээрээ онцлогтой ба Улаанбаатар хот, орон нутгийн нийт 1416 аж ахуйн нэгжийг хамруулан үр дүнг нэгтгэв.

2021 оны Бизнес итгэлийн индекс -0.05 үнэлгээтэй гарсан нь өмнөх оны үнэлгээнээс 0.23 пунктээр өссөн дүн юм. Эдийн засгийн гол салбаруудаар авч үзвэл барилга, үйлчилгээний салбарын бизнес эрхлэгчдийн бизнесийн орчинд итгэх итгэл хамгийн бага байна. Бизнес эрхлэгчид 2021 онд бизнесийн орчинд нэн тэргүүнд шийдвэрлэх асуудлаар “Татварын хувь хэмжээ (ААНОАТ, НӨАТ гэх мэт)”-г онцолсон бол “Бодлогын тогтворгүй байдал” болон “Зээлийн өндөр хүү, хугацаа” зэрэг асуудлуудыг мөн адил бизнесийн орчныг сайжруулахад нэн тэргүүнд шийдвэрлэх шаардлагатай гэжээ.

● ХҮНД СУРТЛЫН ИНДЕКС-2021

МҮХАҮТ-аас Хүнд суртлын индекс судалгааг 2004 оноос эхлэн 2 жил тутам тогтмол явуулж байгаа ба энэхүү судалгаагаар төрийн үйлчилгээ авахад бизнес эрхлэгчдэд тулгарч буй гол бэрхшээл, хүндрэлийг тодорхойлж, судалгааны үр дүнд үндэслэн бодит санал зөвлөмж гаргах, холбогдох байгууллагуудад хүргэн, цаашид бизнес эрхлэгчдийн авч буй төрийн үйлчилгээг хүндрэл чирэгдэл багатай болгоход дэмжлэг үзүүлэх, төрийн үйлчилгээний





хүнд суртлыг багасгах чиглэлд авч хэрэгжүүлэх үйл ажиллагаануудыг эрчимжүүлэх зорилготой. Хүнд суртлын индекс-2021 судалгааг 2021 оны 11 дүгээр сараас эхлэн 2022 оны 1 дүгээр сарыг дуустал явуулж Улаанбаатар хотын 507, 21 аймгийн 244, нийт 751 аж ахуйн нэгж оролцсон.


Хүнд суртлын индекс 2021 онд 2.72 үнэлгээтэй гарсан бөгөөд энэ нь цар тахлын өмнөх үе болох 2018 онтой харьцуулахад 0.18 нэгжээр буурсан. Бизнес эрхлэгчид төрийн үйлчилгээг авахад хүнд суртал ихэссэн байна. Бизнес эрхлэгчдийн зүгээс төрийн байгууллагын уялдаа холбоотой холбогдох үзүүлэлтэд хамгийн бага 2.28 үнэлгээг өгсөн байна. Мөн бизнес эрхлэгчдийн 90 орчим хувь нь төрийн нэг үйлчилгээг авахдаа дунджаар 6 баримт бичиг бүрдүүлж, 3 төрийн албан хаагчтай харьцаж, 13 хоног зарцуулж, 360 мянган төгрөгийн албан зардал гаргадаг байна.

● ЦАР ТАХЛЫН ДАРААХ БИЗНЕСИЙН НӨХЦӨЛ БАЙДЛЫН СУДАЛГАА

Дэлхий дахинаа бий болсон цар тахлын дараах эдийн засаг бизнесийн тодорхойгүй байдал, тээвэр логистик, ханган нийлүүлэлтийн хямрал болон олон улсын геополитикийн нөхцөл байдалд Монгол Улсын бизнес эрхлэгчдэд тулгарч буй бэрхшээлийг тодруулан, санал зөвлөмж гаргах зорилгоор энэхүү судалгааг хийв. Судалгаанд 2022 оны 8 дугаар сарын 25-наас 9 дүгээр сарын 4-ний өдрүүдэд Улаанбаатар хот, орон нутгийн нийт 1073 бизнес эрхлэгчийг хамрууллаа.

Бизнес эрхлэгчдийн 79 хувь нь Түүхий эд материалын үнийн өсөлт, ханган нийлүүлэлтийн тасалдал, ажиллах хүчний хомсдолын нөлөөгөөр тогтвортой, тасралтгүй үйл ажиллагаагаа явуулж чадахгүй байна. Үнийн өсөлтийн дарамт бизнес эрхлэгчдийн 43%-д нь сүүлийн хагас жилийн хугацаанд, 57%-д нь хагас жилээс дээш хугацаанд мэдрэгдэж, бизнесийн ашиг дунджаар 52%-иар буурсан. Аж ахуйн нэгжүүдийн 83%-д нь ханган нийлүүлэлтийн сүлжээнд тасалдал гарч, холбогдох зардал дунджаар 43.7%-иар өсөж, бараа материал хүлээн авдаг хугацаа энгийн үеэс дунджаар 17 хоног ба түүнээс дээш хугацаагаар хоцорч зарим тохиолдолд хэзээ хүлээн авах нь тодорхойгүй болсон. Аж ахуйн нэгжүүдийн 58% нь мэргэжлийн ажиллах хүчний дутагдалд орсон ба 85% нь шаардагдах мэргэжлийн ажиллах хүчээ өөрсдөө сургаж авч байна. Бизнес эрхлэгчид үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахад хил гаалийн удаашрал хүндрэлийг багасгах, санхүүжилт, татварын бодитой дэмжлэг хэрэгтэй байна.





● БУСАД СУДАЛГААНУУД:

- ▶ Аялал жуулчлалын салбарын стратеги боловсруулах суурь судалгаа
- ▶ Барилгын материалын үнийн судалгаа
- ▶ Хотын төвлөрлийг сааруулахад топ аж ахуйн нэгжүүдэд тулгарч буй бэрхшээл, шаардагдах дэмжлэг торуулах судалгаа
- ▶ Компани анх удаа хувьцаагаа олон нийтэд санал болгох (IPO) үйл ажиллагаатай холбогдох бизнес эрхлэгчдийн судалгаа (Санхүүгийн зохицуулах хороо, Монголын хөрөнгийн бирж хамтарсан)
- ▶ Татварын өр төлбөртэй холбоотойгоор бизнес эрхлэгчдэд тулгарч буй хүндрэл, нөхцөл байдлын судалгаа
- ▶ Уул уурхайн бус экспортлогчдын түүвэр судалгаа явуулж байна (Монголбанктай хамтарсан)
- ▶ Монгол Улсын зах зээл, эдийн засгийн ерөнхий тойм (БНЭУ-ын ЭСЯ-ны захиалгаар)
- ▶ Импортлогч аж ахуй нэгжүүдийн захиалгаар тухайлсан бүтээгдэхүүний Монгол Улсын зах зээлийн судалгаа
- ▶ МҮХАҮТ-ын дотоод үйл ажиллагааны CBOT шинжилгээ, цалингийн товч судалгаа
- ▶ МҮХАҮТ-ын гарал үүслийн гэрчилгээ, давагдашгүй хүчин зүйл ба хүнд нөхцөл байдлын гэрчилгээ олгох үйлчилгээний үнийн олон улсын харьцуулсан судалгаа
- ▶ Олон Улсын үйлдвэрлэгчийн үнийн индекс, Монгол Улсын индекстэй харьцуулсан судалгаа
- ▶ Монгол Улсад ирсэн ОХУ-ын жуулчдад тулгарч буй бэрхшээл, дэмжлэг тодруулах судалгаа
- ▶ Аялал жуулчлалын салбарын бизнес эрхлэгчдэд үзүүлж буй цар тахлын нөлөө



ХАМТЫН АЖИЛЛАГАА

Төрийн ба төрийн бус байгууллагууд, нийслэл болон аймгийн засаг захиргааны нэгжүүдтэй хамтын ажиллагаагаа өргөжүүлэх, төрөл бүрийн арга хэмжээ хамтран зохион байгуулах зорилгоор дотоодод нийт 14 газар, гадаадын худалдааг дэмжих 12 байгууллагатай тус тус санамж бичиг байгуулан, хамтран ажилласан.

ДОТООД ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ САНАМЖ БИЧИГ:

Монголбанк

Монголын уул уурхайн
үндэсний ассоциаци

Хууль зүйн хөгжил
шинэтгэлийн хүрээлэн

Төрийн банк

Мэдээлэл технологийн
үндэсний парк

Гадаадын иргэн
харьяатын газар

Голомт банк

Оюуны өмчийн газар

Нийслэлийн бизнес
инновацийн газар

Ти ди би секьюритис
ҮЦХ ХХК

Булган аймгийн Засаг
даргын Тамгын газар

Монгол Улсын

Хөгжлийн банк

Монголын хөл
бөмбөгийн холбоо ТББ

ГАДААД ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ САНАМЖ БИЧИГ:



Оросын Холбооны
Улсын Алс Дорнодын
Приморийн мужийн
Худалдаа Аж
Үйлдвэрийн Танхим

Бүгд Найрамдах Турк
Улсын Истанбул хотын
Худалдааны танхим

Бүгд Найрамдах Хятад
Ард Улсын Олон улсын
худалдааны
маргаанаас урьдчилан
сэргийлэх, зохицуулах
байгууллага (ICDPASO)

Исламын Бүгд
Найрамдах Иран
Улсын Аж үйлдвэр, уул
уурхай, худалдааны
дэд сайд Мохаммад
Мехди Барадаран

Оросын Холбооны
Улсын Якут мужийн
Экспортын төв

Малайз Улсын Дунд
хэмжээний
компаниудын
Консорциум

Малайз Улсын Олон
Улсын Худалдаа Аж
Үйлдвэрийн Танхим

Арабын Нэгдсэн
Эмират Улсын (AIM)
байгууллага

Бүгд Найрамдах
Солонгос Улсын
Гванжу, Ханам хотын
Худалдаа Аж
Үйлдвэрийн Танхим

Бүгд Найрамдах Хятад
Ард Улсын Нинься
Хотон үндэстний
Өөртөө Засах Орны
Худалдааг дэмжих
хороо болон БНХАУ-
аас Монгол Улсад
Хөрөнгө Оруулагчдын
ЗУНХУА Нийгэмлэг

Бүгд Найрамдах Хятад
Ард Улсын Төрийн
өмчит компанийн
хөрөнгө оруулалттай
"Си Си Ай Си Эм Эн"
ХХК

Словак-Монголын
танхим

● ГАДААД ОРНУУДАД ЗОХИОН БАЙГУУЛАГДСАН ТОМООХОН АРГА ХЭМЖЭЭ, УУЛЗАЛТУУД:

Гишүүн байгууллагуудынхаа гадаад харилцаа, хамтын ажиллагааг өргөжүүлэх, эрчимжүүлэх, хөрөнгө оруулалт татах, экспортын тоо хэмжээг нэмэгдүүлэх зорилгоор гадаад, дотоодод томоохон форум, B2B уулзалтууд, туршлага судлах зэрэг арга хэмжээнүүдийг амжилттай зохион байгууллаа. Тухайлбал: БНТурк Улс, Япон Улс, ОХУ, БНКазахстан Улс, БНУзбекистан, Малайз Улс руу бизнес групп зохион байгуулах, дотоодод БНЭнэтхэг Улс, Их Британи, БНСВьетнам Улс, БНСУ, БНХАУ, БНЧех Улс, БНФинланд Улс, ДБНУругвай Улс, ИБНИран Улс, БНПольш Улс, Катар Улс, БНКиргиз Улс, БНБеларусь Улсын бизнес эрхлэгчидтэй нийт 65 цахим болон танхим хосолсон уулзалтыг зохион байгуулсан.

ТУРК - МОНГОЛЫН БИЗНЕС ФОРУМ-2022

Монгол Улсын Их хурлын дарга Г.Занданшатарын Бүгд Найрамдах Турк Улсад хийсэн албан ёсны айлчлалын хүрээнд МҮХАҮТ-аас Турк Улс дахь Монголын Элчин сайдын яам болон Турк Улсын Танхим, Биржүүдийн Холбоо (TOBB)-той хамтран "Турк-Монголын бизнес форум-2022" арга хэмжээг 10 дугаар сарын 15-ны өдөр Турк Улсын нийслэл Анкара хотноо зохион байгуулсан. Энэ удаагийн бизнес форумд Монголын талаас Монгол Улсын Их Хурлын Дарга Г.Занданшатар, Монгол Улсын Их Хурлын гишүүн Ж.Мөнхбат, Монгол Улсаас БНТУ-д суугаа Бүрэн Эрхт Элчин сайд Г.Мөнхбаяр, Хүнс хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Х.Болорчулуун, Байгаль орчин аялал жуулчлалын сайд Б.Бат-Эрдэнэ, Эдийн засаг, хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Х.Батжаргал тэргүүтэй албаны бүрэлдэхүүн болон тээвэр логистик, барилга, дэд бүтэц, хүнсний тоног төхөөрөмж, хөдөө аж ахуй, аялал жуулчлал, гоо сайхны салбарын 20 гаруй бизнес эрхлэгч, Туркийн талаас 30 гаруй бизнес эрхлэгч оролцлоо.





МОНГОЛ-ЯПОНЫ БИЗНЕС УУЛЗАЛТ



МҮХАҮТ, JETRO (Японы гадаад худалдааг дэмжих байгууллага)-тай хамтран "Монгол-Японы бизнес уулзалт"-ыг 12 дугаар сарын 1-ний өдөр Токио хотноо зохион байгууллаа. Бизнес уулзалтад Япон Улсын Эдийн засаг, худалдаа, үйлдвэрийн Дэд сайд Ш.Накатани, Японы гадаад худалдааг дэмжих байгууллага (JETRO) -ын дарга Сасаки, Эдийн засаг, Эдийн засгийн хөгжлийн сайд Ч.Хүрэлбаатар, МҮХАҮТ-ын Ерөнхийлөгч О.Амартүвшин, МҮХАҮТ-ын дарга Т.Дүүрэн, Монгол Улсаас гадаад худалдаа, уул уурхай, барилга, харилцаа холбоо, ноос ноолуур, хүнс, агаарын тээвэр, банк санхүүгийн салбарын нийт 30 орчим тэргүүлэгч аж ахуй нэгжийн 60 орчим төлөөлөл, Япон Улсын 150 гаруй бизнес эрхлэгч оролцов.

МҮХАҮТ нь Япон Улсын Гадаад худалдааг дэмжих байгууллага (JETRO)-тай хоёр улсын хоорондын бизнес хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх чиглэлээр нягт хамтран ажиллаж, төрөл бүрийн уулзалт, үзэсгэлэн арга хэмжээнүүдийг тогтмол зохион байгуулж ирсэн.

Уулзалтын үеэр хоёр байгууллагын харилцааг идэвхжүүлэх, хамтын ажиллагааны тогтвортой механизмыг бий болгоход анхаарах, харилцан мэдээлэл солилцох, туршлага судлах асуудлаар ярилцав. Мөн Монгол Улс Японы зах зээл рүү бараа бүтээгдэхүүнээ экспортлох боломжууд, Монгол-Японы бизнес форум, Япон Улсад Монголын экспортын бараа бүтээгдэхүүний үзэсгэлэнг зохион байгуулахаар хамтран ажиллах талаар харилцан санал солилцов. Уулзалтын төгсгөлд хоёр орны бизнес эрхлэгчдийн хамтын ажиллагааг өргөжүүлэх B2B уулзалт зохион байгуулагдлаа.



 ТУРК-МОНГОЛЫН БИЗНЕС ФОРУМ

МҮХАҮТ, Бүгд Найрамдах Турк Улсын Танхим, Биржүүдийн Холбоо, Монгол-Туркийн Худалдаа, аж үйлдвэрийн танхим хамтран “Турк-Монголын бизнес форум”-ыг Истанбул хотноо 6 дугаар сарын 13-ны өдөр зохион байгууллаа. Форумд Монгол Улсаас Бүгд Найрамдах Турк Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд сайд Г.Мөнхбаяр, МҮХАҮТ-ын Ерөнхийлөгч О.Амартүвшин, Бүгд Найрамдах Турк Улсын Танхим, биржүүдийн холбооны ТУЗ-ийн гишүүн Чэнгиз Гунаи, Монгол-Туркийн Худалдаа, аж үйлдвэрийн танхимын ерөнхийлөгч Эрсин Каска, С.Болдхэт, Монгол Улсаас барилга, уул уурхай, ноос ноолуур, арьс шир, эрүүл мэнд, мах, махан бүтээгдэхүүн, хүнсний бүтээгдэхүүний худалдаа, тээвэр логистикийн үйл ажиллагаа эрхлэгч 15 компанийн 30 гаруй төлөөлөгч, БНТУ-аас мөн салбаруудын компанийн 40 гаруй төлөөлөгч оролцов.



Форумын үеэр Монгол Улсын гадаадын хөрөнгө оруулалт, гадаад худалдаа, бизнесийн орчин, хөнгөн үйлдвэрлэлийн салбарт хөрөнгө оруулах, хамтарч ажиллах боломж, тээвэр логистикийн салбарын хамтын ажиллагаа зэрэг мэдээллийг танилцуулж, хоёр талын бизнес эрхлэгчдийг холбох B2B арга хэмжээг мөн зохион байгууллаа.

МҮХАҮТ, БНТУ-ЫН ТАНХИМ, БИРЖҮҮДИЙН ХОЛБОО (ТОВВ)-ТОЙ
 ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ УУЛЗАЛТ



БНТУ-ын Танхим, Биржүүдийн холбоо (ТОВВ)-той 6 дугаар сарын 17-ны өдөр уулзалт хийлээ. Уулзалтын үеэр хоёр талын хамтын ажиллагааг идэвхжүүлж, бизнесийг дэмжих уулзалт, арга хэмжээг зохион байгуулах, цаашид хамтран ажиллах чиглэлүүдийн талаар санал солилцлоо.



МОНГОЛ-МАЛАЙЗЫН БИЗНЕС УУЛЗАЛТ

МҮХАҮТ нь 9 дүгээр сард хоёр орны худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааг нэмэгдүүлэх, бизнес эрхлэгчдийг холбох, хамтарсан төсөл хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх чиглэлээр Малайзын дунд түвшний компаниудын консорциумтай хамтын ажиллагааны санамж бичиг байгуулсан бөгөөд тус санамж бичгийн хүрээнд MATRADE (Малайз Улсын Гадаад Худалдааны Хөгжлийн Корпораци)-тай хамтран 2 дахь удаагийн "Монгол-Малайзын бизнес уулзалт"-ыг Куала Лумпур хотноо 12 дугаар сарын 6-ны өдөр зохион байгууллаа.

Тус уулзалтад Монголын талаас МҮХАҮТ-ын Ерөнхийлөгч О.Амартүвшин, Ерөнхий нарийн бичгийн дарга С.Баясгалан, гадаад худалдаа, хүнс, сав баглаа боодол, барилга, хувцас үйлдвэрлэлийн салбарын 15 бизнес эрхлэгч, Малайзын талаас Малайз Улсын Гадаад Худалдааны Хөгжлийн Корпорацийн Орлогч дарга Пуан Шариматон Мат Саллах, Малайз Улсын дунд түвшний компаниудын консорциумын Ерөнхийлөгч Каллум Чен, Дэд Ерөнхийлөгч Мартин Анг, Малайзийн Олон улсын худалдаа аж үйлдвэрийн танхимын Ерөнхийлөгч Кристина Тий болон 25 гаруй бизнес эрхлэгч оролцлоо.



Малайз Улсын Гадаад Худалдааны Хөгжлийн Корпорац (MATRADE)-ын Дарга Ноён Датук Мохамед Мустафа Абдул Азиз МҮХАҮТ-ын Ерөнхийлөгч О.Амартүвшин болон албаны төлөөлөгчдийг хүлээн авч уулзан, хоёр орны гадаад худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааны чиглэлээр санал солилцлоо.



Ази, Номхон далайн ХАҮТ-дын холбоо (CACCI)-ны 36 дугаар хурал



Ази, Номхон далайн худалдаа, аж үйлдвэрийн танхимуудын холбооны 36 дугаар хуралдаан Австрали Улсын Мелбоурн хотод 11 дүгээр сарын 28, 29-ний өдөр болж өнгөрлөө. Хуралдаанд МҮХАҮТ-ын Гадаад харилцаа, хамтын ажиллагааны газрын дарга Ц.Гэрэлсайхан оролцон, аялал жуулчлалын салбар хуралдаанд илтгэл тавьж, хэлэлцүүлэгт оролцсон.

● БУСАД УУЛЗАЛТУУД:



МҮХАҮТ, ОХУ-ын Алс дорнодын Приморийн мужийн ХАҮТ-уудын холбоо хамтран Орос-Монголын ажил хэргийн бизнес форумыг 4 дүгээр сарын 27-ны өдөр ОХУ-ын Владивосток хотноо зохион байгууллаа.

МҮХАҮТ, Буриадын ХАҮТ-тай хамтран Худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааг өргөжүүлэх, хөгжүүлэх, бизнесийн таатай орчин бүрдүүлэхэд дэмжлэг үзүүлэх зорилгоор "Орос-Монголын бизнесийн хамтын ажиллагааны форум"-ыг Улаан-Үд хотноо 4 дүгээр сарын 29-ний өдөр зохион байгууллаа.



МҮХАҮТ-ын Ерөнхийлөгч О.Амартүвшин болон Монголын бизнес эрхлэгчдийн төлөөлөл Бүгд Найрамдах Казахстан Улсын Алматы хотын Бизнес эрхлэгчдийн танхимын дарга Айтуар Кошмамбетов, Бүгд Найрамдах Казахстан Улсын Гадаад худалдааны танхимын төлөөлөгч Акеркин Эралиева нартай уулзалт хийсэн.



Узбекистан-Монголын бизнес форумыг Ташкент хотноо анх удаа 6 дугаар сарын 3-ны өдөр амжилттай зохион байгуулав. Монголын талаас 10 гаруй аж ахуйн нэгж, 15 төлөөлөгч, БНУЗУ-ын талаас 20 аж ахуйн нэгжийн төлөөлөл оролцов.

МҮХАҮТ-ын Ерөнхийлөгч О.Амартүвшин нь Бүгд Найрамдах Узбекистан Улсын "СамАвто" компанийн төлөөлөлтэй 10 дугаар сарын 17-20-ны өдрүүдэд хийсэн уулзалтын үеэр тус компанийн үйл ажиллагааг Монголд таниулах, Улаанбаатар хотын нийтийн тээвэрт өөрсдийн үйлдвэрлэлийн SAZ LE60 маркийн автобусыг танилцуулан туршилтын 6 сарын хугацаанд явуулах талаар тохиролцлоо.



Монгол Улс, АНУ хоорондын худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааг өргөжүүлэх, хөрөнгө оруулагчдыг татах, үндэсний үйлдвэрлэл болон монголын үндэсний өв, соёлыг сурталчлан таниулах зорилгоор зохион байгуулагдсан "Монголын өдрүүд - 2022" арга хэмжээг Вашингтон Ди Си хотод амжилттай зохион байгуулсан.

● ДОТООДОД ЗОХИОН БАЙГУУЛАГДСАН АРГА ХЭМЖЭЭ, УУЛЗАЛТУУД:



МОНГОЛ-ЭНЭТХЭГИЙН БИЗНЕС ХЭЛЭЛЦҮҮЛЭГ



“Монгол-Энэтхэгийн худалдаа, технологи, аялал жуулчлалын хамтын ажиллагааг өргөжүүлэх нь” бизнес хэлэлцүүлгийг 3 дугаар сарын 25-ны өдөр зохион байгуулж, 100 аж ахуйн нэгжийн төлөөлөл оролцлоо.



МОНГОЛ-ИХ БРИТАНИЙН БИЗНЕС ФОРУМ


Монгол-Их Британийн бизнес форумыг 4 дүгээр сарын 13-ны өдөр зохион байгуулсан. Хоёр улс 1963 онд дипломат харилцаа тогтоосноос хойш 60 гаруй жилийн хугацаанд улс төр, худалдаа, эдийн засаг, соёл боловсрол, хүмүүнлэгийн харилцааг хөгжүүлж ирсэн. Цаашид худалдааны эргэлтийг нэмэгдүүлэх, худалдааны тэнцлийг ойртуулах, хөрөнгө оруулалтын түншлэлийг өргөжүүлэхээр хэлэлцэв.



МОНГОЛ-ВЬЕТНАМЫН БИЗНЕС ФОРУМ




Монгол-Вьетнамын бизнес форум 6 дугаар сарын 22-ны өдөр зохион байгуулсан. Монголын талаас 250 гаруй аж ахуйн нэгж, Вьетнамын талаас 38 аж ахуйн нэгж оролцлоо.



МОНГОЛ-БЕЛАРУСИЙН БИЗНЕС ФОРУМ

МҮХАҮТ, Монгол Улсад суугаа Бүгд Найрамдах Беларусь Улсын Элчин Сайдын Яам, Беларусийн Худалдаа Аж Үйлдвэрийн Танхимтай хамтран “Монгол-Беларусь бизнес форум”-ыг 9 дүгээр сарын 23-ны өдөр зохион байгууллаа. Форумын нээлтэд Бүгд Найрамдах Беларусь Улсаас Монгол Улсад суугаа Бүрэн Эрхт Элчин сайд Горелик Дмитрий Николаевич, МҮХАҮТ-ын Ерөнхийлөгч О.Амартүвшин нар оролцов.



● БУСАД ТОМООХОН УУЛЗАЛТУУД:

- ▶ Бүгд Найрамдах Чех Улсаас Монгол Улсад суугаа ЭСЯ, МҮХАҮТ, Чехийн Эдийн Засгийн Танхим хамтран “Монгол, Чехийн В2В Бизнес форум”-ыг 10 дугаар сарын 12-ны өдөр зохион байгуулав. Нийт 80 гаруй ААН оролцлоо.

- ▶ “ОХУ-ын эдийн засгийн тусгай арга хэмжээний тухай” танилцуулах уулзалтыг 3 дугаар сарын 17-ны өдөр зохион байгуулж, 150 гаруй бизнес эрхлэгч оролцсон.
 - ▶ Монгол-Киргизийн хөнгөн үйлдвэрийн салбарын бизнес уулзалтыг 2022 оны 3 дугаар сарын 30-ны өдөр зохион байгуулж, хөнгөн үйлдвэрийн салбарын 50 аж ахуйн нэгж оролцлоо.
 - ▶ Монгол-Польшийн бизнес уулзалтыг 4 дүгээр сарын 6-ны өдөр зохион байгуулж, Польшийн талаас 5, Монголын талаас 30 аж ахуйн нэгж оролцсон. Польшийн аж ахуйн нэгжүүд танилцуулгаа хийн, хоёр талын компаниудын B2B уулзалт зохион байгууллаа.
 - ▶ БНХАУ-ын барилгын материал үйлдвэрлэгч аж ахуйн нэгжүүдийг Монголын барилгын салбарынханд танилцуулах цахим уулзалтыг 5 дугаар сарын 18-ны өдөр зохион байгуулав. БНХАУ-ын 7 аж ахуйн нэгж, Монголын талаас 25 аж ахуйн нэгжийн төлөөлөл оролцлоо.
 - ▶ Монгол-Сингапурын бизнес вебинарыг 6 дугаар сарын 9-ний өдөр зохион байгуулсан бөгөөд Монгол, Сингапурын 50 гаруй аж ахуйн нэгж оролцлоо.
 - ▶ Олон улсын хөрөнгө оруулалтын чуулга уулзалт (AIM):
АНЭУ-д “Хөрөнгө оруулалтын парадигмын шилжилт. 2022 онд болсон 11 дэх удаагийн уулзалтад 174 оны 11,500 гаруй оролцогч оролцсон ба танилцуулах арга хэмжээний үеэр МҮХАҮТ-ын Ерөнхий нарийн бичгийн дарга С.Баясгалан, AIM хөрөнгө оруулалтын чуулга уулзалтын Ерөнхий захирал ноён Валид Фаргал нар Монгол Улсад гадаадын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх чиглэлээр хамтран ажиллах Санамж бичиг байгууллаа.
 - ▶ МҮХАҮТ-ын Ерөнхийлөгч О.Амартүвшин, УИХ-ын гишүүн, Монгол-БНСУ-ын Парламентын бүлгийн дэд дарга Д.Өнөрболор нар БНСУ-ын Гванжу, Ханам хотын ХАҮТ-ын Ерөнхийлөгч Ким Пүн-Ху, дэд ерөнхийлөгч Хан Ён-Сан, И Гён-Ин, И Хи-Гён, Су Жин-Вон болон бизнесийн төлөөлөлтэй уулзалт хийлээ. “СИГМА Монголиа”-тай хамтарч, Монгол-Солонгосын бизнес уулзалтыг хоёр удаа зохион байгуулж, нийт 90 компанийн 110 гаруй төлөөлөл оролцсон.
 - ▶ БНСУ-ын Гёнгангбук-ду мужийн хүнсний бүтээгдэхүүн, хүүхдийн хэрэглэл, гэр ахуйн бараа бүтээгдэхүүн, тоног төхөөрөмж, будаг, технологийн бүтээгдэхүүн үйлдвэрлэгч 13 аж ахуй нэгжтэй B2B уулзалтыг 8 дугаар сарын 8-ны өдөр зохион байгуулсан.
 - ▶ Бүгд Найрамдах Казахстан Улсын Элчин сайдын яамтай хамтарч, Монгол-Казахстаны бизнес форумыг 10 дугаар сарын 26-нд /цахим/ зохион байгуулсан.
 - ▶ Монгол-ОХУ-ын Калининград мужийн худалдаа, эдийн засгийн бизнес уулзалтын зохион байгуулсан. Нийт 15 компанийн төлөөлөл оролцсон.
 - ▶ Канад Улсын Парламентын Сенатын танхимын дарга эрхэмсэг ноён Жорж Ж.Фюри тэргүүтэй төлөөлөгчид айлчлалынхаа хүрээнд МҮХАҮТ-д зочлоход бэлтгэл ажлыг хангаж, албан уулзалтыг зохион байгуулав.
 - ▶ ОХУ-ын Марий Эл Улсын бизнес эрхлэгчидтэй хийх B2B уулзалтыг 10 дугаар сарын 25-нд зохион байгууллаа. Уулзалтад Монголын талаас 15 ААН оролцлоо.
-



АРГА ХЭМЖЭЭ

МҮХАҮТ нь 2022 онд гишүүн байгууллагуудаа цаг үеийн мэдээ мэдээллээр хангах, тэдний сүлжээг өргөжүүлэх, туршлага солилцох, хамтын ажиллагааг нь дэмжих чиглэлээр олон талт арга хэмжээг зохион байгууллаа.

● “ЦАР ТАХЛЫН ЭРСДЭЛИЙГ АМЖИЛТТАЙ ДАВАН ТУУЛАХ ТУРШЛАГА, ХҮНИЙ НӨӨЦИЙН ОНОВЧТОЙ МЕНЕЖМЕНТ” ХЭЛЭЛЦҮҮЛЭГ



МҮХАҮТ-аас “Компаниуд цар тахлын эрсдэлийг амжилттай даван туулах туршлага, хүний нөөцийн оновчтой менежмент” сэдэвт уулзалт хэлэлцүүлгийг зохион байгуулсан. Уулзалтад танхим болон цахимаар 130 гаруй компанийн төлөөлөл оролцсон юм.


Хэлэлцүүлэгт АПУ ХК, Скайхайпермаркет, ХААН банк, Эйч Ар клуб, Эйч Ар консалтинг фирм ХХК, Чонос ЖиЖи Мед ХХК, Зочлох

үйлчлэх салбарын сургалт хөгжлийн төвийн төлөөллүүд оролцон, “Хүнсний үйлдвэрт цар тахлын давалгааг амжилттай даван туулсан арга туршлага”, “Цар тахлын дараах зочлох үйлчилгээний салбарын чиг хандлага”, “Үйлчилгээний байгууллагад цар тахлын давалгааг амжилттай даван туулсан арга туршлага”, “Байгууллага доторх халдвар хамгааллыг амжилттай хэрэгжүүлэх зарим боломжууд” сэдвүүдээр танилцуулга хийн, хэлэлцүүлэг өрнүүлсэн.

● CEO RADAR

Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн Танхимын дэргэдэх Бизнес Академиас санаачлан зохион байгуулсан “CEO RADAR” арга хэмжээ амжилттай болж, 100 гаруй компанийн 300 орчим удирдах түвшний ажилтан оролцсон.

Гүйцэтгэх болон дундаас дээш түвшний удирдлагууд арга туршлагаасаа хуваалцаж, “BIG QUESTION & BIG IDEA” хэлэлцүүлгийн үеэр цар тахлын дараах шинэ хэвийн байдалд бизнесээ сэргээхэд тулгамдаж буй асуудлууд, гарц шийдлээ хамтдаа тодорхойлсон.



● “БИЗНЕС БА ЭМЭГТЭЙЧҮҮД” зөвлөлдөх уулзалт



МҮХАҮТ-ын дэргэдэх Бизнес эрхлэгч эмэгтэйчүүдийн зөвлөлөөс зохион байгуулсан “Эмэгтэйчүүдийн эдийн засгийн оролцоог нэмэгдүүлэх нь” 21 аймгийн зөвлөлдөх уулзалт 5 дугаар сарын 24-ний өдөр боллоо. Уулзалтад Улаанбаатар хотын болон 21 аймгийн төлөөлөл 240 гаруй бизнес эрхлэгч оролцлоо.

● НАМРЫН НОГООН ӨДРҮҮД

“Намрын ногоон өдрүүд”-үндэсний үйлдвэрлэл” нэгдсэн арга хэмжээний хүрээнд жижиг дунд болон өрхийн үйлдвэрлэгчдийн өдөрлөг болов. Тус өдөрлөгийн үеэр ХХААХҮ-ийн Судалгаа хөгжлийн төв, МҮХАҮТ хамтран бизнес эрхлэгч, үйлдвэрлэгч, сонирхогч талуудын хамтын ажиллагааг өргөжүүлэх B2B уулзалт, бизнесийн байгууллагууд хооронд хамтран ажиллах Санамж бичиг зурах ажиллагааг зохион байгууллаа.



“Намрын ногоон өдрүүд-2022” нэгдсэн арга хэмжээнд нийслэл, 21 аймгаас 400 гаруй оролцогч 2000 орчим бүтээгдэхүүнээрээ оролцож, 670 сая гаруй төгрөгийн борлуулалт хийсэн байна.





B2B уулзалтад үр тариа, жимс ногоо тариалагч боловсруулагч, хүнс хөдөө аж ахуйн тоног төхөөрөмж нийлүүлэгч, эрдэм шинжилгээ туршилт судалгааны байгууллага, зөгийн бал болон бусад хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэгч аж ахуй нэгж, хувь хүмүүс оролцсоноос гадна "Улаанбаатар түншлэл-2022" олон улсын үзэсгэлэнд оролцогч ОХУ-ын компаниудын төлөөлөл ирж оролцсон.



● Монгол - Европын ХАҮТ болон Кластеруудтай уулзалт хийлээ

МҮХАҮТ болон Европын Холбооны Ойрх Дорнод, Номхон далайн бүс хариуцсан төлөөлөгч уулзалтад Европын Холбооны санхүүжилтээр 2017-2021 онд хэрэгжсэн Монголын Худалдааг Дэмжих Төсөл (TRAM)-ийн дэмжлэгээр байгуулагдсан экспортын бараа бүтээгдэхүүний 4 кластерийн төлөөлөл, Монголын Экспортын Кластер Сүлжээ ТББ, Монгол - Европын ХАҮТ-ыг оролцсон бөгөөд Европын Холбоо, Монгол Улс хооронд худалдааг дэмжих тухай өмнөх хамтын ажиллагаа, цаашдын хийгдэх ажлуудын талаар санал солилцсон.



● **ЕВРОПЫН ХОЛБООНД МОНГОЛЫН АНХНЫ ГАЗАР ЗҮЙН ЗААЛТЫГ БҮРТГҮҮЛСЭН ТУРШЛАГА**

Монголын анхны газар зүйн заалтыг ЕХ-нд бүртгүүлсэн туршлага сургалт, уулзалтыг 5 дугаар сарын 6-ны өдөр зохион байгуулав. Уулзалтад газар зүйн заалтын ерөнхий ойлголт, ач холбогдол, тавигдах шаардлагууд, газар нутгийн, байгаль, цаг уурын онцлог, ард иргэдийн өв соёл шингэсэн брэнд бүтээгдэхүүнийг бий болгоход газар зүйн заалт хэрхэн холбогдож буй талаар болон 2022 оны 1 дүгээр сард Увс аймгийн чацаргана үйлдвэрлэгчдийн холбооны "Увсын чацаргана" газар зүйн заалтыг Монголоос анх удаа Европын Холбоонд бүртгүүлэхэд гарсан сорилтууд, туршлагаас хуваалцах зорилгоор төрийн болон төрийн бус байгууллага, эрдэм шинжилгээ, судалгааны байгууллагуудын удирдлага, албан хаагчдад нэгдсэн ойлголт, мэдээллийг хүргэлээ.



● **"ӨВЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ-АСУУДАЛ, ШИЙДЭЛ" ХЭЛЭЛЦҮҮЛЭГ**



Монгол Улсын Засгийн газраас 2023-2025 оныг 3 жил дараалсан аялал жуулчлалын зочлох жил болгон зарлаж, салбарыг дэмжих, хөгжүүлэх ажлын хэсгүүд гарч ажиллаж байна.

МҮХАҮТ-ын дэргэдэх Аялал жуулчлалын зөвлөлөөс Нийслэлийн аялал жуулчлалын газартай хамтран "Өвлийн аялал жуулчлал-

Асуудал, Шийдэл" хэлэлцүүлгийг 11 сарын 18-ны өдөр зохион байгууллаа. Хэлэлцүүлэгт салбарын 60 гаруй бизнес эрхлэгч оролцож санал бодлоо солилцсон.

● **"ШҮҮХИЙН БУС ЖУРМААР МАРГААН ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ НЬ" ХЭЛЭЛЦҮҮЛЭГ**

Монголын Олон Улсын Арбитраас санаачлан Монгол Улсын Хууль зүй, дотоод хэргийн яам, Шүүхийн ерөнхий зөвлөл, Нийслэлийн Иргэний хэргийн давж заалдах шатны шүүх, Монголын өмгөөлөгчдийн холбоо, Монголын нотариатчидын танхимтай хамтран "Шүүхийн бус журмаар маргаан хянан шийдвэрлэх нь" сэдэвт хэлэлцүүлгийг амжилттай зохион байгуулсан.



2022

МОНГОЛЫН ҮНДЭСНИЙ ХУДАЛДАА АЖ ҮЙЛДВЭРИЙН ТАНХИМ
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН



ШАГНАЛ, ШАЛГАРУУЛАЛТ

● МОНГОЛ УЛСЫН 2021 ОНЫ ТОП 100 АЖ АХУЙН НЭГЖ



Монгол Улсын Засгийн газар, Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн танхим хамтран нийгэм, эдийн засгийн хөгжилд бодитой хувь нэмэр оруулж буй "ТОП-100 аж ахуйн нэгж"-ийг эрэмбэлж, өргөмжлөх үйл ажиллагааг 21 дэх жилдээ зохион байгууллаа.



● 2021 ОНЫ ШИЛДЭГ АЖ АХУЙН НЭГЖҮҮДИЙН ТУГИЙГ МАНДУУЛЛАА



МҮХАҮТ-аас жил бүр уламжлал болгон шалгаруулдаг "Оны онцлох 10 аж ахуйн нэгж"-ээр шалгарсан шилдэг аж ахуйн нэгжийн туг өргөх ёслолын ажиллагааг 2022 оны 1 дүгээр сарын 14-ний өдөр зохион байгуулсан.



● ENTREPRENEUR 2022

Бизнесийн салбарын нэр хүнд, үнэ цэнийг тодорхойлж ирсэн Монгол Улсын оны онцлох аж ахуйн нэгжийг шалгаруулдаг "Entrepreneur 2022" Меркури цом гардуулах ёслол хүндэтгэлийн арга хэмжээг 25 дахь жилдээ зохион байгуулав. Бизнесийн салбарт өндөр амжилт гаргаж, нийгэм, эдийн засгийн хөгжилд бодитой хувь нэмэр оруулж буй онцлох ААН, байгууллага, бизнес эрхлэгчдээс Гран при, Оны онцлох 10 аж ахуйн нэгж, тодорхой салбарын ENTREPRENEUR, GREENPRENEUR номинациар тэргүүлсэн шилдэг аж ахуй нэгжүүдийг тодрууллаа.

● ОНЫ ОНЦЛОХ АЖ АХУЙ НЭГЖИЙН АЯН



2021 оны ООААН-ээр шалгарсан 3 компанийн үйл ажиллагаатай танилцах, туршлага судлах аянг зохион байгуулсан бөгөөд нийт 92 гаруй бизнес эрхлэгчийг хамруулсан.

- Эрдэнэт Үйлдвэр ТӨҮГ
- Эрдэнэс Тавантолгой ХК
- Хаан Банк



● МҮХАҮТ-ын нэрэмжит шагнал

МҮХАҮТ-аас Монгол Улсын эдийн засгийн чадавхийг нэмэгдүүлэх, хөгжлийг хурдасгах, үндэсний үйлдвэрлэлийг дэмжих, бичил, дунд бизнес болон ногоон эдийн засаг, ногоон бизнес, компанийн нийгмийн хариуцлагыг хөгжүүлэх, хувийн хэвшлийг дэмжихэд бодитой хувь нэмэр оруулж буй гадаад, дотоодын 50 байгууллага, аж ахуйн нэгж, 486 бизнес эрхлэгчийг өөрийн нэрэмжит дараах нэр бүхий шагналуудаар шагнаж урамшууллаа.



14

Business
excellence
award



105

Хийморь
одон



4

Silk
road



8

Entrepreneurship
spirit




21

Шилдэг
залуу
бизнесмен



236

Хүндэт
жуух



98

Хүндэт
өргөмжлөл




ҮЗЭСГЭЛЭН ЯАРМАГ

2022 онд дэлхий нийтэд цар тахал дөнгөж намжиж зарим улс орон хил гаалиа нээх үед МҮХАҮТ нь гишүүн байгууллагуудынхаа бизнесийн үйл ажиллагааг дэмжихээр гадаад, дотоод үзэсгэлэнгүүдийг амжилттай зохион байгууллаа.

● ГАДААД ҮЗЭСГЭЛЭН


“ДУБАЙ ЭКСПО-2020”



Уг экспод Дэлхийн 192 орны бие даасан асар оролцож нийт 24 сая гаруй үзэгч үзэж сонирхсон бол Монгол Улсын асарт 2021 оны 10 дугаар сарын 1-нээс 2022 оны 3 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар 365562 үзэгч үзэж сонирхсон тоо баримт байна.

Үзэсгэлэнгийн хугацаанд Монгол Улсын асарт Монголын үндэсний үйлдвэрлэгч 20 орчим ААН-үүдийн гар урлал, бэлэг дурсгал, ноолуур, арьс ширэн эдлэл, авдар модон эдлэл, оньсон тоглоом, гоо сайхан зэрэг салбарын бараа бүтээгдэхүүнийг дэлгэн оролцож нийт 111,859 ам.доллар буюу 343,630,848 төгрөгийн борлуулалт хийсэн.

Дэлхийн “ЭКСПО 2020”-д 2021 оны 11 дүгээр сарын 16-ны өдөр “МОНГОЛ УЛСЫН ҮНДЭСНИЙ ӨДӨР”-ийг зохион байгуулж Монголын төр болон бизнесийн төлөөлөл, Гадаад харилцааны яам, Соёлын яам, МҮХАҮТ оролцсон. Мөн Монголын хөрөнгө оруулалтын бизнес форум зохион байгуулагдаж Монголын талаас 50 бизнес эрхлэгч, АНЭУ-ын талаас 50 гаруй бизнес эрхлэгч оролцсон.



ОЛОН УЛСЫН ФРАНЧАЙЗИНГИЙН ҮЗЭСГЭЛЭН



Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн Танхим нь АНУ-ын Нью-Йорк хотноо зохион байгуулагдсан 30 дахь удаагийн Олон улсын франчайзингийн үзэсгэлэнд бизнес групп зохион байгуулан оролцсон. Энэ удаагийн үзэсгэлэнд АНУ-ын бизнес эрхлэгчдээс гадна олон улсын франчайз брэндүүд цугласнаараа онцлог болж, франчайзын шилдэг экспертүүд

сургалт, семинар зохион байгуулан өргөн цар хүрээтэй зохион байгуулагдсан юм.

МҮХАҮТ-ын энэ удаагийн группт БСБ сервис ХХК, Синержи групп ХХК, Ухаа сар ХХК, Петровис ойл ХХК, Симатай промoшн ХХК, Ландекс ложистикс, Эгүлэн пос ХХК-ийн төлөөлөл оролцож Монгол Улсаас НҮБ-ын дэргэд суугаа Элчин сайд, Байнгын төлөөлөгч В.Энхболд МҮХАҮТ-ын төлөөлөгчдийг хүлээн авч уулзан, АНУ-тай бизнес эрхлэх боломжуудын талаар санал солилцож, цаашид хамтран ажиллаж бизнест нь дэмжлэг үзүүлэхээ илэрхийлсэн.

“СОЕХ FOOD WEEK” СОЛОНГОСЫН ХҮНСНИЙ ҮЗЭСГЭЛЭН

МҮХАҮТ-аас БНСУ-ын хүнсний салбарын “СОЕХ FOOD WEEK 2022” үзэсгэлэнд оролцох бизнес аялал зохион байгууллаа. БНСУ-ын Сүүл хотын СОЕХ үзэсгэлэнгийн төвд зохион байгуулагдсан уг үзэсгэлэнд Солонгос Улсын дотоодын болон гадаадын нийт 1000 аж ахуй нэгж оролцож, 1400 талбай засагдсан байна.



Бизнес аялалд хүнсний болон гадаад худалдааны чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг 22 ААН-ийн төлөөлөл оролцож туршлага судлан, бизнесийн хамтын ажиллагаагаа өргөжүүлсэн. Мөн оролцогчид БНСУ-ын 1959 онд байгуулагдсан бяслаг, хөлдөөсөн бүтээгдэхүүн, төрөл бүрийн амтлагч, соус, гурилан бүтээгдэхүүний түүхий эд үйлдвэрлэгч “Choheong Corporation” хүнсний үйлдвэртэй танилцсан юм.

5 ДАХЬ УДААГИЙН ХЯТАДЫН ОЛОН УЛСЫН ИМПОРТЫН ЭКСПО




2022 оны 11 дүгээр сарын 5-10-ны хооронд зохион байгуулагдсан 5 дахь удаагийн “Хятадын Олон Улсын Импортын Экспо”-гийн Үндэсний хэсэгт Монгол Улсын асрыг виртуал орчинд тохижуулан аялал жуулчлал, хөрөнгө оруулалтын талаар сурталчилснаас гадна Монгол Улсын ноолууран бүтээгдэхүүн, гоо сайхан, тэжээл бордоо үйлдвэрлэгч 5 ААН-ийн сурталчилгааг байршуулан оролцуулсан.

ДОТООД ҮЗЭСГЭЛЭН

ЖИЖИГ ДУНД ҮЙЛДВЭРИЙН БҮТЭЭГДЭХҮҮН, ҮЙЛЧИЛГЭЭ, ТЕХНОЛОГИ-2022 ҮЗЭСГЭЛЭН




МҮХАҮТ, Жижиг, дунд үйлдвэрийн газар, Нийслэлийн Засаг даргын Тамгын газар хамтран жил бүр уламжлал болгон зохион байгуулдаг “Жижиг Дунд Үйлдвэрийн Бүтээгдэхүүн, Үйлчилгээ, Технологи-2022” Олон улсын үзэсгэлэн худалдааг 24 дэх жилдээ 2022 оны 5 дугаар сарын 19-22-ны өдрүүдэд Мишээл экспо төвд зохион байгуулсан.



УЛААНБААТАР ТҮНШЛЭЛ - 2022 ОЛОН УЛСЫН ҮЗЭСГЭЛЭН

“Улаанбаатар түншлэл-2022” олон улсын үзэсгэлэн Мишээл экспо төвд 2022 оны 9 дүгээр сарын 22-25-ны өдрүүдэд амжилттай зохион байгуулагдаж өндөрлөсөн. Үзэсгэлэнд Бүгд Найрамдах Беларусь Улс, Оросын Холбооны Улс, Тайвань, Малайз Улсаас 65 аж ахуй нэгжийн 100 гаруй бизнес эрхлэгч хүрэлцэн ирж, Монголын аж ахуй нэгжүүдтэй уулзалт хийсэн бөгөөд нийт 1134 уулзалт, B2B болсноос 305 уулзалт нь хамтран ажиллах гэрээ, санамж бичиг байгуулах, салбар дэлгүүрээ нээх болсон зэрэг үр дүнтэй уулзалт болсон.





ТӨСӨЛ ХӨТӨЛБӨР

● ОРГАНИК МОНГОЛ ХӨТӨЛБӨР



Хөтөлбөрийг хамтран хэрэгжүүлэгч байгууллагууд



Органик Монгол хөтөлбөр нь Бичил, жижиг дунд бизнес эрхлэгчдэд жилийн 12%-ийн хүүтэй зээлийг 3-36 сарын хугацаатай олгодог юм.

Зээлийн эргэн төлөлт 100% байдаг.

Хөтөлбөр хэрэгжиж эхэлснээс хойш нийт 250 гаруй төслийг санхүүжүүлээд байна.

2022 онд газар тариалангийн бүс нутаг болох Сэлэнгэ, Дархан-Уул аймгуудын шаардлага хангасан нийт 8 төсөлд 120.0 сая төгрөгийн зээл олгосон.

Зээлд хамрагдсан аж ахуйн нэгжүүд болон хувь хүмүүсийг Намрын ногоон өдрүүд болон Улаанбаатар Түншлэл-2022 үзэсгэлэнд оролцуулж, дэмжин ажиллав.

МҮХАҮТ нь цаашид хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлж, 21 аймагт байгаль орчинд ээлтэй бичил, жижиг төслүүдийг дэмжих боломж эрэлхийлэн ажиллаж байна.



● МҮХАҮТ-ЫН ДЭРГЭД БИЗНЕС ЭРХЛЭГЧ ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН ТӨВ



МҮХАҮТанхим болон Азийн сан ОУБ-ын 2016 оноос эхлүүлсэн стратеги түншлэлийн хүрээнд 2022 оны 10 дугаар сарын 14-ний өдөр МҮХАҮТ-ын дэргэд Бизнес Эрхлэгч Эмэгтэйчүүдийн Төвийг байгууллаа.

Бизнес эрхлэгч эмэгтэйчүүдийн төв нээгдсэнээс хойших үйл ажиллагааны тоон үзүүлэлт:

- Эмэгтэйчүүдийн бизнес эрхлэлтийг дэмжих 2-р шатны инкубаторын гүнзгийрүүлсэн сургалт
- 6 долоо хоногийн хугацаанд 30 сэдвээр 11 удаагийн сургалт
- Зөвлөх үйлчилгээ, арга хэмжээ
- 8 сэдвээр 48 эмэгтэйд зөвлөх үйлчилгээ, 25 эмэгтэйг хамруулсан 1 удаагийн арга хэмжээ

● SWITCH ASIA "МОНГОЛЫН САРЛАГИЙН ШИРНИЙ КЛАСТЕРЫГ ЧАДАВХЖУУЛАХ" ТӨСӨЛ ҮЙЛ АЖИЛЛАГААГАА ЭХЛҮҮЛЛЭЭ

Хэрэгжих хугацаа: 2021/12/08 - 2025/12/09



"Монгол Улсын ургамлын аргаар идээлүүлсэн сарлагийн арьс шир ба арьсан бүтээгдэхүүний кластерийн био-арьс болон био-арьсан бүтээгдэхүүн үйлдвэрлэх чадавхийг бэхжүүлэх нь" буюу Тогтвортой Сарлагийн Арьс (Sustainable Yak Leather) төсөл нь SWITCH-Asia хөтөлбөрийн хүрээнд Европын Холбооны санхүүжилтээр хэрэгжиж буй төсөл юм. Төслийн нээлтийг 5-р сарын 28-нд зохион байгуулсан.



Монгол Улсын сарлагийн нөөцийн 81 хувийг бүрдүүлдэг төслийн зорилтот Архангай, Баянхонгор, Хөвсгөл, Өвөрхангай дөрвөн аймагт малчин, мал эмнэлгийн ажилтнууд, мал нядалгааны газрын ажилтнууд, сарлагийн арьс үйлдвэрлэл, нийлүүлэлтийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй борлуулагч, худалдаа эрхлэгчдэд зориулсан 5 өдрийн сургалтыг зохион байгууллаа.

● АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГОЛ ЧИГЛЭЛ АВТО ЗАМ ДАГУУХ ШИНЭЭР БАЙГУУЛАХ ТҮР БУУДАЛЛАХ ЦЭГ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЦОГЦОЛБОР БАЙГУУЛАХ ТӨСӨЛ



Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр болон Төрөөс аялал жуулчлалыг хөгжүүлэх талаар баримтлах бодлогод тусгагдсаны дагуу Аялал жуулчлалын гол чиглэл дагуу 200-250 км тутамд тогтоосон байршлуудад стандартын шаардлага хангасан үйлчилгээний цогцолбор бүхий түр буудаллах цэгүүдийг төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд байгуулах

ажлын хэсэгт МҮХАҮТ, МҮХАҮТ-ын дэргэдэх Аялал жуулчлалын зөвлөлийн төлөөлөл ажиллаж байна.

2022 онд ажлын хэсгийн баталсан нийт 43 байршлын 21 байршилд түр буудаллах цэг, үйлчилгээний цогцолбор барьж байгуулах аж ахуйн нэгжүүдтэй хамтран ажиллах гэрээ байгуулж хувийн хэвшлийн бүтээн байгуулалтыг дэмжин ажиллалаа.

● ЗӨГИЙН БАЛНЫ ЭКСПОРТЫН КЛАСТЕР ШИНЭЭР БАЙГУУЛАГДЛАА

Японы Олон Улсын Хамтын Ажиллагааны Байгууллага ЖАЙКА-гийн дэмжлэгтэйгээр хэрэгжиж буй MONMAP-AVC төсөл нь ХХААХҮЯ-тай хамтран Монгол Улсын ХАА-н нэмүү өртгийн сүлжээний Мастер төлөвлөгөө боловсруулах зорилготой ажиллаж байна. Мастер төлөвлөгөөг боловсруулахын тулд туршилтын төслүүд хэрэгжүүлэх, кластер хөгжүүлэх, судалгаа хийх, сургалт зохион байгуулах зэрэг ажлууд хийгдэж байгаа бөгөөд экспортын кластер хөгжүүлэх чиглэлээр МҮХАҮТ-тай 2020 оноос хамтран ажиллаж байна.



Энэ хүрээнд 2022 оны 5 дугаар сарын 10-нд Зөгийн балны кластер ТББ-ыг Хуулийн этгээдийн улсын бүртгэлд бүртгүүлж, 10 дугаар сарын 26-ны өдөр нээлт хийлээ. Нээлтээр кластерийн гишүүнчлэлийг эхлүүлж, зөгийн балын экспортод бид бэлэн үү? сэдвээр хэлэлцүүлэг зохион байгуулсан.

● “ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН ЭДИЙН ЗАСГИЙН ЧАДАВХЫГ БЭХЖҮҮЛЭХ” ХӨТӨЛБӨРИЙН ДҮНД 50 ОРОЛЦОГЧ БИЗНЕСЭЭ ЭХЛҮҮЛЛЭЭ



Азийн хөгжлийн банк, ХЗДХЯ, МҮХАҮТ хамтран хэрэгжүүлж буй “Эмэгтэйчүүдийн эдийн засгийн чадавхыг бэхжүүлэх” зөвлөх үйлчилгээг МҮХАҮТ, орон нутаг дахь ХАҮТ-ууд, зөвлөхүүдийн хамт 2020 оны 10 дугаар сарын 26-наас хоёр жилийн хугацаанд амжилттай гүйцэтгэж дууслаа.

Зөвлөх үйлчилгээний хүрээнд Улаанбаатар хотын Налайх, Сонгинохайрхан дүүрэг болон

Увс, Сүхбаатар, Сэлэнгэ аймгийн 240 гаруй эмэгтэйд хувь хүний хөгжил, хууль эрх зүй, бизнесийн төсөл боловсруулах арга зүй, менежмент, борлуулалт, маркетинг, санхүү, нягтлан бодох бүртгэлийн багц сургалтыг хоёр үе шаттай явуулжээ. Мөн бизнесийн санааг хэрэгжүүлэхэд зориулж, дээрх таван байршлын 50 эмэгтэйд 346 сая төгрөгийн бичил тэтгэлгийн санхүүжилтийг олгосон байна.

● “БИЗНЕСИЙН ЁС ЗҮЙ, ШУДАРГА БАЙДЛЫГ БЭХЖҮҮЛЭХ” ТӨСӨЛ



МҮХАҮТ нь “Транспэрэнси Интернэшнл Монгол” ТББ, “Рио Тинто Монгол” ХХК-тай хамтран “Бизнесийн ёс зүй, шударга байдлыг бэхжүүлэх” төслийг хэрэгжүүлж эхэлсэн. Төслийн хүрээнд 2021 онд МҮХАҮТ-ын дэргэд “Бизнесийн ёс зүйн төв”-ийг байгуулан, хамтын үйл ажиллагаагаа амжилттай эхлүүлсэн бөгөөд төсөл хэрэгжсэн нэг жилийн үйл ажиллагааны тайланг түнш байгууллагууд хэлэлцэн, уг төслийг дахин нэг жилээр сунгаж, үргэлжлүүлэн ажиллаж байна.

“Бизнесийн Ёс Зүйн Төв” нь төслийн хүрээнд 2022 онд Бизнесийн байгууллагуудад ёс зүйн дүрэм боловсруулах, хянах, туслалцаа үзүүлэх, Засаглалын тогтолцоог бий болгоход дэмжлэг үзүүлэх, Бизнесийн болон мэргэжлийн ёс зүй, шударга байдлын сургалтыг зохион байгуулах, холбогдох хэвлэмэл материал, мэдээллийг боловсруулах, эмхэтгэх зэрэг ажлуудыг хийж гүйцэтгэлээ. Үүнд:

СУРГАЛТ

Нийт 12 удаагийн сургалт зохион байгуулж 224 хүнийг хамруулав. Үүнээс 5 захиалгат сургалт болон 6 сургалтын модуль боловсруулав.



ХЭЛЭЛЦҮҮЛЭГ

4 удаагийн дугуй ширээний уулзалтыг “Татварын Ёс Зүй”, “Ёс зүйтэй манлайлал” зэрэг сэдвүүдээр зохион байгуулав.



УУЛЗАЛТ ЯРИЛЦЛАГА


Төр, хувийн хэвшлийн түншлэлийг сайжруулж, бизнес эрхлэгчдийн санал, санаачилга, хамтын ажиллагааг нэмэгдүүлэх зорилгоор уулзалтын зочноор Авлигатай Тэмцэх Газрын Дэд дарга Г.Азжаргал уригдан бизнес эрхлэгчидтэй санал бодлоо солилцсон. Төрийн албаны хүнд суртал, авлигыг таслан зогсоох чиглэлээр төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааг өргөжүүлэх, МҮХАҮТ-ын дэргэдэх Бизнесийн ёс зүйн төвийн үйл ажиллагааг уялдуулан ажиллах талаар санал солилцсон.

ЦАХИМ АЯН



“Ёс Зүй - Тогтвортой Бизнес” сэдэвтэй дижитал кампанит ажил зохион байгуулж 201,500 хүнд хүрсэн.

ЦАХИМ НОМЫН САН



Цахим номын сан нь 6 сарын хугацаанд 18,585 хандалтыг авсан бол хэлэлцүүлэг, уулзалтууд удаа дараалан цацагдаж хувиараа бизнес эрхлэгчид болон ААН-үүдэд хүрэн амжилттай ажилласан

ЧУУЛГАН

МҮХАҮТ-ын дэргэдэх Комплаенсын үндэсний зөвлөлтэй хамтран “Комплаенс, бизнесийн ёс зүйн анхдугаар чуулган”-ыг зохион байгуулсан. Уг чуулганд нийт 200 орчим бизнесийн байгууллагын төлөөлөл оролцож, бизнес орчин дахь шударга, ёс зүйтэй байдлыг бэхжүүлэхийн төлөө санаа бодлоо солилцсон байна. Чуулганд оролцогчдын зүгээс ёс зүйтэй бизнес тогтвортой үргэлжилж, урт хугацаанд оршин тогтнодог, ёс зүй нь бизнесийн үйл ажиллагаанд чухал талаар болон комплаенсын талаарх нэгдсэн ойлголттой болсон.



СУДАЛГАА

Нийт 102 байгууллагаас бизнесийн ёс зүй, шударга байдлын хэрэгцээг тодорхойлох асуулга судалгаа явуулж дүгнэлт гаргасан билээ.




ТАНХИМЫН ҮЙЛЧИЛГЭЭ


● ГАРАЛ ҮҮСЛИЙН ГЭРЧИЛГЭЭ

МҮХАҮТ нь экспортын барааны гарал үүслийг гэрчлэх бүрэн эрхийнхээ хүрээнд иргэн, аж ахуйн нэгжүүдэд гарал үүслийн гэрчилгээг тогтмол олгож байгаа бөгөөд 2022 онд гарал үүслийн гэрчилгээний системийн бүрэн шинэчлэлт хийж автоматжуулан хэрэглээнд нэвтрүүлээд байна. Энэхүү системийг нэвтрүүлснээр хурдан шуурхай үйлчилгээ авах, төлбөр тооцоогоо тухай бүрд нь шийдэж явах, урьдчилгаа төлбөрийн хэрэгслийг ашиглах, гэрчилгээ авах хүсэлт илгээхээс бэлэн болох үе шат бүрийн мэдэгдлийг бүртгэлтэй цахим шуудангийн хаягаараа авах гэх мэт олон давуу талууд хэрэглэгчдэд бий болсон.

ГАРАЛ ҮҮСЛИЙН ГЭРЧИЛГЭЭ



2022 ОНД ОЛГОГДСОН ГАРАЛ ҮҮСЛИЙН ГЭРЧИЛГЭЭ /төрлөөр/




● ОЮУНЫ ӨМЧ

Бизнес эрхлэгчдийн оюуны өмчийн эрхийг хамгаалах чиглэлээр МҮХАҮТ нь 1970 оноос хойш Монгол Улсын Оюуны Өмчийн Газраас олгосон №01 дугаартай тусгай зөвшөөрлийн хүрээнд оюуны өмчийн итгэмжлэгдсэн төлөөллийн үйл ажиллагааг МҮХАҮТ-ын Патент, барааны тэмдэг, газар зүйн заалтын газар хариуцан ажиллаж байна.

Оюуны өмчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчид нь оюуны өмчийн чиглэлээр 6 танхимын сургалт, орон нутагт 5 цахим сургалт, 5 арга хэмжээнд илтгэл танилцуулж, бизнес эрхлэгчдийг мэдээллээр ханган ажилласан.

ОЮУНЫ ӨМЧИЙН МЭДҮҮЛЭГ




2022 ОНД ОЛГОГДСОН ОЮУНЫ ӨМЧИЙН МЭДҮҮЛЭГ /төрлөөр/

Ашигтай загварын патент	1
Бүтээгдэхүүний загварын патент	1
Шинэ бүтээлийн патент	8
Барааны тэмдэг	163


● ЭКСПЕРТИЗ

Монгол Улсын ХАҮТ-ын тухай хуулиар олгогдсон экспорт, импортын барааны тоо, чанарын талаар магадлагаа гаргах хөндлөнгийн шалгалт (экспертиз) хийж, олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн нотолгоо (сертификат)-г олгож байна.



● ГЭНЭТИЙН БУЮУ ДАВАГДАШГҮЙ ХҮЧИН ЗҮЙЛ БОЛОН ХҮНД, НӨХЦӨЛ БАЙДЛЫН ГЭРЧИЛГЭЭ


Иргэн, аж ахуй нэгжүүдээс “Гэнэтийн буюу давагдашгүй хүчин зүйл” болон “Хүнд нөхцөл байдал”-ын гэрчилгээ гаргуулах хүсэлт Ковид-19 цар тахал, ОХУ болон Украин Улсын хоорондын дайны нөхцөл байдлаас үүдэлтэйгээр сүүлийн жилүүдэд огцом өссөн байна.



● АТА КАРНЕЙ

Монгол Улс 2004 онд Истанбулын конвенцэд нэгдэн орж, МҮХАҮТ нь АТА карнейг олгох эрх бүхий байгууллагаар томилогдон ажиллаж байгаа билээ.

2022 оны турш АНУ, БНСУ, Европын Холбоо, Япон Улс, Швейцарын Холбооны Улс, Испанийн Хант Улс, ХБНГУ, Тайландын Хант Улс, Их Британи улсуудад нийт 15 АТА Карней баримт бичгийг олгосон байна.





СУРГАЛТ



МҮХАҮТ-аас Гишүүд болон бизнес эрхлэгчдэд зах зээлээ өргөжүүлэх, өрсөлдөх чадвараа нэмэгдүүлэхэд нь дэмжлэг үзүүлэх, мэдлэг мэдээллээр хангах зорилгоор урт болон богино хугацааны сургалт, албан байгууллага дээрх захиалгат сургалтуудыг цахим болон танхим хосолсон хэлбэрээр зохион байгуулж 390 орчим хүнийг сургалтад хамруулсан байна.



● ХАРВАРД МЕНЕЖМЕНТОР ХӨТӨЛБӨР



Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн Танхимаас байгууллагын гүйцэтгэх удирдлага, дунд шатны менежерүүд, гарааны бизнес эрхлэгчдэд зориулсан "1000 CEO, 1000 хүчирхэг компани" хөтөлбөрийн хүрээнд Бизнес Академи, Harvard Business Publishing-тай хамтран албан ёсны эрхтэйгээр Harvard ManageMentor хөтөлбөрийг хэрэгжүүлж байна.



Дэлхийн шилдэг боловсролыг эх орондоо, эх хэлээрээ эзэмшиж, Монгол менежерүүдэд манлайллын ур чадвар, карьераа өсгөх боломж олгож байгаа энэхүү хөтөлбөрийн хоёр болон гурав дахь курсийг нийт 137 гаруй менежер, дунд, түүнээс дээш шатны удирдлага төгсч Харвард Бизнес Пабблишингийн сертификатыг гардаж аваад байна.

● “КОВИДЫН ДАРААХ БИЗНЕСИЙН ДАРААХ ЭРЧИМЖҮҮЛЭХ МЕНЕЖМЕНТИЙН ХӨТӨЛБӨР” СУРГАЛТ

Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн Танхимын “1000 CEO, 1000 ХҮЧИРХЭГ КОМПАНИ” хөтөлбөрийн хүрээнд Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч Д.Сумъяабазарын дэмжлэгтэйгээр бизнесийн бүх салбарын жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчдэд зориулсан “Ковидын дараах бизнесийг эрчимжүүлэх” менежментийн хөтөлбөрийг “Нийслэлийн жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих төв” НӨҮГ-тэй хамтран хэрэгжүүлж байна.

Уг хөтөлбөрийн эхний сургалтыг 5 долоо хоногийн турш танхим болон цахим хосолсон хэлбэрээр явагдаж хөтөлбөрийн эхний элсэлтэд 20 гаруй жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгч хамрагдсан.

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫН ЗАХИРАГЧ Д.СУМЬЯАБАЗАРЫН ДЭМЖЛЭГТЭЙГЭЭР ХЭРЭГЖИЖ БҮЙ

КОВИДЫН ДАРААХ БИЗНЕСИЙГ ЭРЧИМЖҮҮЛЭХ МЕНЕЖМЕНТИЙН ХӨТӨЛБӨР

1000 CEO 1000 ХҮЧИРХЭГ КОМПАНИ

- МОДУЛЬ 1: СТРАТЕГИ БА ИННОВАЦИ
- МОДУЛЬ 2: ДИЖИТАЛ ШИЛЖИЛТ
- МОДУЛЬ 3: ОЛОН УЛСАД ГАРАХ БҮЮУ ШИНЭ ЗАХ ЗЭЭЛИЙГ НЭЭЖ
- МОДУЛЬ 4: АЛСЫН ХАВАА, ЭРХЭМ ЗӨРИЛГӨ, ҮНЭТ ЗҮЙЛС
- МОДУЛЬ 5: МАРКЕТИНГИЙН СТРАТЕГИ БОЛОВСРУУЛАХ
- МОДУЛЬ 6: БЭРЭНДИЙН КЭРС СУДАЛГАА
- МОДУЛЬ 7: БАЙГУУЛЛАГЫН ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН БҮТЭЦ
- МОДУЛЬ 8: АЖИЛТНЫ ОРЛОЦОО БА ӨӨРЧЛӨЛТИЙГ МАНЛАЙЛАХ
- МОДУЛЬ 9: ӨНДӨР ГҮЙЦЭТГЭЛТЭЙ АЖЛЫН БАЙРНЫ СУДАЛГАА
- МОДУЛЬ 10: ҮР АШИГТАЙ ҮЙЛ АЖИЛЛАГАА
- МОДУЛЬ 11: САНХҮҮ БА САМХҮҮГИЙН МЕНЕЖМЕНТ
- МОДУЛЬ 12: ӨСӨЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙН ПРАКТИК, ТУРШЛАГА

MENTORS

● “CEO EXCELLENCE” ХӨТӨЛБӨР

Шилдэг “CEO” нар дундаж “CEO”-оос хэрхэн ялгардаг вэ?

Шинэ үеийн удирдагч манлайлагч нарт зориулсан “CEO EXCELLENCE” хөтөлбөрийг 2022 оны 6 дугаар сарын 21-22-ны өдрүүдэд зохион байгуулсан.

- 5 “CEO CORE ACTION” модуль
- 7 “CEO CHALLENGE” хэлэлцүүлэг
- 3 “HARVARD BUSINESS SCHOOL”

кейс ажиллагаанаас бүрдсэн сургалтын формат, контент, заах арга зүйн хувьд шинэчлэгдсэн хөтөлбөрийг MCLINSEY & COMPANY-ийн 2300 CEO-оос авсан судалгаанд суурилсан CEO EXCELLENCE-ийн баяжуулан боловсрууллаа.

CEO EXCELLENCE

2022.06.21-2022.06.22 | TUESDAY, WEDNESDAY

- 5 CEO CORE ACTION МОДУЛЬ
- 7 “CEO CHALLENGE” ХЭЛЭЛЦҮҮЛЭГ
- 3 HARVARD BUSINESS SCHOOL КЕЙС АЖИЛ

LEAD (МАНЛАЙЛАХ)
DIRECT (УДИРДАХ)
COMMUNICATE (ХАЯАХ)
ALIGN (ТӨЛӨВЛӨХ)
CATALYZE (ЭРЭГЖҮҮЛЭХ)



МОНГОЛЫН ОЛОН УЛСЫН АРБИТР



Монголын Олон Улсын Арбитр нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг удирдан явуулах, арбитрын журмаар хэрэг хянан шийдвэрлүүлэхээр хүсэлт гаргасан иргэд, ААН-д тасралтгүй, түргэн шуурхай үйлчилгээг үзүүлэн ажиллаж байна.

МОНГОЛЫН ОЛОН УЛСЫН АРБИТРЫН БҮРЭЛДЭХҮҮН

МҮХАҮТ-ын дэргэдэх
Монголын Олон Улсын
арбитрчид

110

78

Монголын
Арбитрч

32

Олон улсын
Арбитрч



БИЗНЕСИЙН МАРГААНЫГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ ҮЙЛЧИЛГЭЭ

2022 онд нийт 201 нэхэмжлэл шинээр хүлээн авч, 281 хэрэгт арбитрын ажиллагаа явуулан өмнөх жилүүдээс хамгийн олон тооны буюу 175 маргааныг шийдвэрлэсэн юм. Мөн хэрэг хянан шийдвэрлэх дундаж хугацаа 6 сар байсан.

ХҮЛЭЭН АВСАН
ХЭРГИЙН ТОО



ШИЙДВЭРЛЭСЭН
ХЭРГИЙН ТОО



ГЭРЭЭНИЙ ТӨРЛӨӨР

Даатгалын гэрээ	2	Хамтран ажиллах гэрээ	10	Зээлийн гэрээ	77
Тээвэр зуучийн гэрээ	3	Түрээсийн гэрээ	14	Бусад	7
Франчайзын гэрээ	3	Худалдах, худалдан авах гэрээ	39		
Зуучлалын гэрээ	6	Ажил гүйцэтгэх гэрээ	39		

МОУА нь иргэн, аж ахуй нэгж байгууллагуудад 353 лавлагаа, тодорхойлолт гарган үйлчилгээ үзүүлсэн байна.

● ГАДААД ХАРИЛЦАА БА ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ САНАМЖ БИЧИГ:



- Монголын өмгөөлөгчдийн холбоо
- Легал дата ХХК
- БНТУ-ын Истанбулын Арбитрын Төв (ISTAC)
- Монголын хуульчдын холбоо
- Монголын Олон Улсын ба Үндэсний Спортын Арбитр
- Монголын Уул Уурхайн Үндэсний Ассоциаци



● ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭ, СУДАЛГАА:



Монголын хуульчдын холбоо, Монголын нотариатчдын танхим, Санхүү, эдийн засгийн их сургууль, Сити их сургууль, Шихихутуг их сургуулийн төгсөгчдийн холбоотой хамтран зохион байгуулсан “Шүүхийн бус журмаар маргаан шийдвэрлэх нь” сэдэвт эрдэм шинжилгээний хурлын нийтлэлийн эмхэтгэлийг эрхлэн гаргасан.

“Арбитрын толь бичиг – Монгол, Англи, Орос, Латин тайлбар толь” номыг эрхлэн гаргасан.

● АРБИТРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ТАНИУЛАХ СУРГАЛТ



Монголын Олон Улсын Арбитраас арбитрын байгууллагын үйл ажиллагаа, давуу тал, онцлогийн талаар танин мэдүүлэх, мөн Гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйлийн талаар мэдээлэл өгөх сургалтыг аж ахуйн нэгжүүдэд тогтмол зохион байгуулсан.

Түүнчлэн Зүүн хойд Азийн олон улсын арилжааны маргаан шийдвэрлэх анхдугаар хуралд Монголын олон улсын арбитрыг төлөөлөн арбитрч Г.Хонгор цахим илтгэл тавьсан.




● “АРБИТРЫН ПОДКАСТ” НЭВТРҮҮЛЭГ

2022 оноос эхлэн МОУА нь “Арбитрын подкаст” нэвтрүүлгийг бэлтгэн олон нийтэд тогтмол хүргэж ажиллаж байна.

“АРБИТРЫН ПОДКАСТ”-ЫН АНХНЫ ДУГААР

Хууль зүйн шинжлэх ухааны доктор, МУИС-ийн Хууль зүйн сургуулийн дэд профессор, МОУА-ын арбитрч Т.Мэндсайхан багш оролцлоо.

Анхны подкастаар арбитрын байгууллагын үүсэл хөгжил болоод талууд арбитрын байгууллагаар хэрэг маргаанаа шийдвэрлүүлэхийн тулд юу анхаарах ёстойг, мөн арбитрыг сонирхон судалж буй оюутан залуус юуг мэдвэл зохих талаар товч ярилцсан юм.



“АРБИТРЫН ПОДКАСТ”-ЫН ХОЁР ДАХЬ ДУГААР

МОУА-ын арбитрч, МОУА-ын Арбитрчдын зөвлөлийн дарга Т.Алтангэрэл /LL.M/ оролцож, олон улсын арбитрын байгууллагын үйл ажиллагаа, хэрэг хянан шийдвэрлэхтэй холбоотой шинэлэг зохицуулалтууд, арбитр - эвлэрүүлэн зуучлалын ялгааны талаар ярилцсан.



ЦАХИМ АРБИТР

МОУА нь өөрийн www.arbitr.mn цахим хуудсыг Англи хэл дээрх хувилбартай болгож ажиллалаа.


МАРГААН ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ АЖИЛЛАГААНЫ ЖУРМЫН ШИНЭЧЛЭЛ



Арбитрын журмаар маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны журмын шинэчилсэн найруулгын төслийг боловсрууллаа.



ТАНХИМЫН ДОТООДОД ХЭРЭГЖҮҮЛСЭН АЖИЛ



Нийгэм цаг үе, үнийн өсөлт, инфляцын өөрчлөлт, хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ, цалингийн судалгаа зэргийг харгалзан үзэж Танхимын цалингийн хэмжээг шинэчлэн баталж нийт ажилтнуудын цалинг 20%-аар нэмэгдүүлсэн.




Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль 2022 оны 5 дугаар сарын 1-ний өдрөөс хэрэгжиж эхэлсэнтэй холбоотой цаг бүртгэлийн хурууны программыг өөрчлөн "Timely" цаг бүртгэлийн систем рүү шилжин, нийт ажилтнууд өөрсдийн гар утсаараа цахимаар цаг бүртгэлээ бүртгүүлдэг болсон.



Хөдөлмөрийн тухай хууль шинэчлэн батлагдсантай холбоотой Танхимын хөдөлмөрийн дотоод хэм хэмжээ болох Хөдөлмөрийн дотоод журам, Хөдөлмөрийн гэрээ бусад гэрээ, ажлын байрны тодорхойлолт, тушаал зэрэг баримт бичгийг 2022 оны 1 дүгээр сарын 2-ны өдрөөс эхлүүлэн хуульд нийцүүлэн шинэчлэн боловсруулан мөрдөж эхэлсэн.

● МЭДЭЭЛЭЛ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ НЭГДСЭН СИСТЕМ

МҮХАУТ-ын албан ёсны цахим хуудас www.mongolchamber.mn, Үндэсний хэмжээний аж ахуйн нэгжүүдийн мэдээллийн нэгдсэн сүлжээ www.trademongolia.mn, МҮХАУТ-ын дэргэдэх Монголын Олон Улсын Арбитр www.arbitr.mn, Хүний эрхийг хүндэтгэдэг, хариуцлагатай бизнесийн байгууллагуудад зориулсан цахим хуудас www.bizhumanrights.mn зэрэг танхимын гишүүн байгууллагуудад үйлчилгээ, мэдээ




мэдээлэл хүргэх цахим сувгуудыг ойлгомжтой, хүртээмжтэй, эмх цэгцтэй байлгахгаар тогтмол шинэчлэн сайжруулалтыг хийж гүйцэтгэж байна.



Танхимаас зохион байгуулдаг шалгаруулалтуудын үйл явцыг автоматжуулах зорилготой award.mongolchamber.mn шалгаруулалтын системийг хийж гүйцэтгэн нэвтрүүлээд байна. Ингэснээр жил бүр уламжлал болгон зохион байгуулдаг Entrepreneur, Lady Entrepreneur арга хэмжээнүүдэд оролцогчдын материалыг онлайнаар хүлээн авах, ирүүлсэн материалуудыг шалгаруулах, шалгаруулалтын комиссын гишүүд онлайнаар шууд шалгаруулалтыг хийх, шалгарсан компаниудын мэдээллийг нэгтгэх, түүх болгон үлдээх, статистик тоон мэдээлэл гарган авах гэх мэтчилэн олон боломж бий боллоо.



МҮХАҮТ-ын Grand Hall их танхимд дуу, хөгжмийн тоног төхөөрөмжүүд болох дууны холигч пульт, зурвас хуваарилагч, чадлын өсгөгчүүд, шингэн нам яригчууд, мониторууд, хайрцаг (рак), түгжээ, гинж, бэхэлгээ, цахилгаан болон дууны холбогч кабелиуд, гэрлийн удирдлага, гэрэл гэрэлтүүлгийн хамт иж бүрэн шинэчлэлтийг хийж өдөр тутмын үйл ажиллагаандаа ашиглаж байна.






Хурал, уулзалтын том жижиг өрөө, танхимуудад болж буй арга хэмжээнүүдийг цахимаар зохион байгуулах, шууд дамжуулах бүрэн боломжтой байдлаар шийдэж өгсөн.



МҮХАҮТ-ын ажилтнуудын албан хэрэгцээнд ашиглагдаж байсан 30 гаруй компьютерыг ажлын хэрэгцээнд зориулсан үзүүлэлт бүхий сүүлийн үеийн компьютеруудаар солин, шинэчлэлт сайжруулалтыг хийсэн. Ингэснээр орчин үеийн үйлдлийн систем, программ хангамжуудыг ашиглах, суралцах, ажлыг түргэн шуурхай хийх боломжуудаар ханган ажиллаж байна.





САЛБАР ТАНХИМ

Салбар танхимуудын 2021 оны үйл ажиллагааны тайлангийн хурлыг 2022 оны 3 дугаар сарын 15,16-ны өдрүүдэд зохион байгуулав. Тайлангийн хуралд 21 аймгийн салбар танхимын дарга, менежер нийт 40 хүн хамрагдав. Энэ үеэр салбар Танхимын дарга, менежерүүдэд зориулан сургалтууд зохион байгуулав. 2021 онд үйл ажиллагаагаар тэргүүлсэн шилдэг салбар Танхим, менежерүүдийг тодруулан шагнаж урамшуулав. 2022 онд салбар Танхимуудын үйл ажиллагааг улирал тутам дүгнэн, үр дүнгийн урамшууллыг олгосон.

CHAMBERBUS ХӨТӨЛБӨР:

Орон нутгийн бизнес эрхлэгчдийг Улаанбаатар хотын томоохон үйлдвэрүүдтэй танилцуулах, туршлага судлах, МҮХАҮТ-ын үйл ажиллагаатай танилцуулах хөтөлбөрийг Өмнөговь, Сүхбаатар, Хэнтий, Дорнод, Орхон, Өвөрхангай аймгуудын салбар Танхимуудын хүсэлтээр зохион байгууллаа. Хөтөлбөрийн хүрээнд орон нутгийн бизнес эрхлэгчдийг 15 /давхардсан тоогоор/ үйлдвэрийн үйл ажиллагаатай танилцуулж, сургалтад хамруулсан. Нийт оролцогч 212.

СУРГАЛТ, МЭДЭЭЛЭЛ:

Орон нутгийн бичил жижиг дунд бизнес эрхлэгчдэд зөвлөгөө мэдээлэл сургалтыг тухай бүр зохион байгуулан ажилласан. Тухайлбал: Татварын хуулийн шинэчилсэн найруулга, Хөдөлмөрийн тухай хууль, Санхүүгийн боловсрол олгох сургалтуудыг зохион байгууллаа.

БҮХ ГИШҮҮДИЙН ХУРАЛ:

Булган, Өвөрхангай, Баянхонгор, Говь-Алтай, Орхон, Хөвсгөл, Дархан-Уул аймаг дахь ХАҮТ-ын бүх гишүүдийн хурлыг зохион байгуулав. Говь-Алтай, Хөвсгөл, Дархан-Уул аймаг дахь ХАҮТ-ын дарга болон тэргүүлэгч гишүүд шинээр сонгогдсон. Энэ үеэр орон нутгийн бизнес эрхлэгчдэд МҮХАҮТ-ын үйл ажиллагааны танилцуулга мэдээлэл, хийгдсэн судалгааны тайлан, дүгнэлтийг танилцуулсан. Мөн Татварын багц хуулийн талаарх сургалтуудыг хийлээ.

САЛБАР ТАНХИМ	ЦАХИМ ШУУДАН	ХАЯГ
Архайнгай аймаг	arkhangai@mongolchamber.mn	Архангай аймаг, Эрдэнэбулган сум, 4-р баг Хасу компанийн байр
Баян-Өлгий аймаг	bayan-ulgii@mongolchamber.mn	Баян-Өлгий аймаг, Өлгий сум, 5-р баг, Засаг даргын Тамгын газрын байр 1 давхар
Баянхонгор аймаг	bayankhongor@mongolchamber.mn	Баянхонгор аймаг, Номгон сум, 1-р баг, Нутгийн удирдлагын ордон, 1-р давхар
Булган аймаг	bulgan@mongolchamber.mn	Булган аймаг, 5-р баг, Хунтайж төв, 303 тоот, Булган салбар танхим
Говь-Алтай аймаг	govi-altai@mongolchamber.mn	Говь-Алтай аймаг, Есөнбулаг сум, Харзат баг, Тулга-Алтай ХХК-ийн байр
Говьсүмбэр аймаг	govisumber@mongolchamber.mn	Говьсүмбэр аймаг, Сүмбэр сум, 3-р баг, 1-р байр 2 тоот
Дархан-Уул аймаг	darkhan@mongolchamber.mn	Дархан-Уул аймаг, Дархан сум, 10-р баг, Чингис хаан банкны байр 205 тоот
Дорнод аймаг	dornod@mongolchamber.mn	Дорнод аймаг, Хэрлэн сум, 4-р баг, Политехникийн коллежийн хашаанд Дорнод
Дорноговь аймаг	dornogovi@mongolchamber.mn	Дорноговь аймаг, Сайншанд сум, 2-р баг, Бадрах Өргөө үйлчилгээний төвийн 1 давхарт, 01 тоот
Дундговь аймаг	dundgovi@mongolchamber.mn	Сайнцагаан сум, 7-р баг, Мэдээлэл харилцаа сүлжээний ХХК-ийн 3-р давхарт 305 тоот
Завхан аймаг	zavkhan@mongolchamber.mn	Завхан аймаг, Улиастай сум, Холбооны байр 102 тоот
Орхон аймаг	orkhon@mongolchamber.mn	Орхон аймаг, Баян-Өндөр сум, Захиргааны 3-р байр, 203тоот
Өвөрхангай аймаг	uvurkhangai@mongolchamber.mn	Өвөрхангай аймаг, Арвайхээр сум, 5-р баг, Аюуш баатрын талбай, Өвөрхангайд үйлдвэрлэв төв, ХАҮТ
Өмнөговь аймаг	umnugovi@mongolchamber.mn	Өмнөговь аймаг, Даланзадгад сум, Говь сэндс 308 тоот
Сүхбаатар аймаг	sukhbaatar@mongolchamber.mn	Сүхбаатар аймаг, Баруун-Урт сум, Нутгийн удирдлагын ордон, 312 тоот ХАҮТ
Сэлэнгэ аймаг	selenge@mongolchamber.mn	Сэлэнгэ аймаг, Сүхбаатар сум, Мэдээлэл холбооны сүлжээ ХХК-ийн байр
Төв аймаг	tuv@mongolchamber.mn	Зуунмод сум, Баруун Зуунмод баг, Ганвоны гудамж, Төр захиргааны 2-р байр, 202 тоот
Увс аймаг	Uvs@mongolchamber.mn	Увс аймаг, Улаангом сум, 5-р баг, Барилгын хороо 8-1Б Тайж-Од ХХК байр
Ховд аймаг	khovd@mongolchamber.mn	Ховд аймаг, Жаргалант сум, Наран баг, Жаргалант төв 101 тоот
Хөвсгөл аймаг	khuvsgul@mongolchamber.mn	Хөвсгөл аймаг, Мөрөн сум, ЗДТГ-ын Б корпус 3 давхар
Хэнтий аймаг	khentii@mongolchamber.mn	Хэнтий аймаг, Чингис хот, 1-р баг, Оч манлай ХХК-ийн байр

● МҮХАҮТ-ЫН ДЭРГЭДЭХ ЗӨВЛӨЛҮҮД

1. Эдийн засгийн бодлогын зөвлөл
2. Хууль зүйн бодлогын зөвлөл
3. Комплаенсийн үндэсний зөвлөл
4. Компанийн нийгмийн хариуцлагын зөвлөл
5. Худалдааны бодлогын зөвлөл
6. Худалдааг хөнгөвчлөх, тээвэр ложистикийн зөвлөл
7. Аялал жуулчлалын зөвлөл
8. Ноос ноолуурын зөвлөл
9. Итгэмжлэгдсэн лабораторуудын зөвлөл
10. Соёлын бүтээлч үйлдвэрлэлийг дэмжих зөвлөл
11. Бизнес эрхлэгч эмэгтэйчүүдийн зөвлөл
12. Чөлөөт бүс хөрөнгө оруулалтын нэгдсэн зөвлөл
13. ОХУ-тай хамтран ажиллах зөвлөл
14. БНХАУ-тай хамтран ажиллах ажил хэргийн зөвлөл
15. Япон Улстай хамтран ажиллах ажил хэргийн зөвлөл
16. Монгол Туркийн хамтарсан танхим
17. Монгол Австрийн хамтын ажиллагааны зөвлөл

● МҮХАҮТ-ЫН ГАДААД УЛС ОРНУУДЫН ТӨЛӨӨЛӨГЧИД

1. Бүгд Найрамдах Сингапур Улс
2. Бүгд Найрамдах Солонгос Улс
3. Бүгд Найрамдах Армени Улс
4. Бүгд Найрамдах Австри Улс
5. Хонгконг
6. Бүгд Найрамдах Итали Улс
7. Их Британи
8. Бүгд Найрамдах Словак Улс
9. Бүгд Найрамдах Франц Улс
10. Холбооны Бүгд Найрамдах Герман Улс
11. Бүгд Найрамдах Хятад Ард Улс
12. Америкийн Нэгдсэн Улс
13. Бельгийн Хаант Улс
14. Швейцарын Холбооны Улс
15. Шведийн Хант Улс
16. Япон Улс
17. Бүгд Найрамдах Турк Улс
18. Бүгд Найрамдах Социалист Вьетнам Улс


2022

МОНГОЛЫН ҮНДЭСНИЙ ХУДАЛДАА АЖ ҮЙЛДВЭРИЙН ТАНХИМ
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

● ХАВСРАЛТ

2022

МОНГОЛЫН ҮНДЭСНИЙ ХУДАЛДАА АЖ ҮЙЛДВЭРИЙН ТАНХИМ
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН



SCAN ME



МОНГОЛЫН ҮНДЭСНИЙ ХУДАЛДАА АЖ ҮЙЛДВЭРИЙН ТАНХИМ

Монгол Улс, Улаанбаатар хот 17011, Хан-Уул дүүрэг, 15-р хороо,
Махатма Гандигийн гудамж, МҮХАҮТ-ын байр



Утас: (+976) 77277070



Факс: (+976) 11 324620



www.mongolchamber.mn



[mongolchamber](https://www.facebook.com/mongolchamber)



chamber@mongolchamber.mn



[mongol_chamber](https://twitter.com/mongol_chamber)